# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ГЭЛЭГЖАМЦЫН ЭНХТАЙВАНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | | | |
| 1 | 1.1.Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах | Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх ажлын үзүүлэлтийн өсөлт | - | 50% | **Биелэлт:**<br>Нэг. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр:<br>-ХХХ-ийн Нэгдүгээр хэсгийн 12 зүйлийн хүрээнд тодорхойлсон 36 арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган гаалийн албан хаагчдын хүртээл болгохын зэрэгцээ Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо, СЯ, ГХЯ-нд хүргүүлж, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг ханган ажилласан.<br>-Энэхүү тайланд тусгасан 2025 онд хэрэгжилтийг хангах үүрэг амлалт авсан “Зүйл 3.Барааны урьдчилсан шийдвэр, Зүйл 10.3 Олон улсын стандарт ашиглах” арга хэмжээний хэрэгжилтийг ГХЯ ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хороонд хүргүүлж Монгол Улсын хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.<br>Хоёр. ДГБ-ын “Меркатор” хөтөлбөрийн хүрээнд<br>-Монголын гаалийн байгууллагын худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаанд онош зүйн шинжилгээ хийсэн тайланд тусгасан 16 зөвлөмжийн хүрээнд 56 арга хэмжээг төлөвлөсөн дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилт ирүүлэх дотоод зурвасыг ГЕГ-ын ЗББНДБ-д хүргүүлж, нэгдсэн тайланг гаргасан.<br>-ХХХ-ийн зарим заалтын хэрэгжилтийг Үндэсний хороонд хүргүүлэх тайланд тусган, СЯ, ГХЯ, ЭЗХЯ-нд (2025.06.13, №01-2487, №01-2488, №01-2493) хүргүүлсэн.<br>Гурав. “Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч”:<br>НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (ХХБХ)-ын Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч системд 27 арга хэмжээний хэрэгжилт, бусад мэдээллийг оруулж, Үндэсний хорооны гишүүдийн уялдаа холбоог хангаж, уг системд нэвтрэх чиглэлээр сургалт зохион байгуулж, ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодын 34 шинэ хэрэглэгчийг уг системд бүртгэн, үйл ажиллагааг идэвхжүүлсэн.<br>https://reformtracker.org/site/dashbord/66e577a1f5f38fcda70e3918?page=Dashboard<br>**Хүрсэн түвшин:** | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ДГБ, ДХБ, НҮБ-ын ХХБХ, ОУВС, СЯ, ГХЯ, ЭЗХЯ, Европын Холбооны Монгол Улсын Гадаад худалдааг хөгжүүлэх төсөл болон ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороо, худалдаа эрхлэгч нартай 5 албан бичиг, 73 цахим захидал солилцон, 21 уулзалт, 3 сургалтыг цахим болон танхимаар хамтран зохион байгуулж, гаалийн байгууллагын цахим хуудас, НҮБ-ын ХХБХ-ын Худалдааг хөнгөвчлөх Шинэчлэлийн хөтөч программд 15 мэдээлэл бэлтгэн, олон нийтийн хүртээл болгон, дараах үр дүнд хүрсэн:<br><br>-ДХБ-ын ХХХ-ийн нэгдүгээр хэсгийн 12 зүйлийн хүрээнд тодорхойлсон 36 арга хэмжээний хэрэгжилтийг дэлгэрэнгүй байдлаар ГХЯ-нд хүргүүлж, ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг болж, хэлэлцээрийн хэрэгжилтийг 86.4 хувиас 95.2 хувьд хүргэж, 8.8 хувиар нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. https://www.tfadatabase.org/en/members/mongolia. Дээрх тайланд 2025 онд хэрэгжилтийг хангах үүрэг амлалт хүлээсэн "Зүйл 3. Барааны урьдчилсан шийдвэр, Зүйл 10.3 Олон улсын стандарт ашиглах" арга хэмжээний хэрэгжилт тусгагдсан.<br><br>-Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагыг ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хорооны 2025.06.04-05-ны өдөр зохион байгуулсан уулзалтад танилцуулж, Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон улсад сурталчилсан үр дүнд хүрсэн.<br><br>-Худалдааг хөнгөвчлөх 36 арга хэмжээ, бусад асуудлыг дэлгэрэнгүй байдлаар тусгаж, хамтран ажиллаж, хэрэгжилтийн үнэлгээ хийх НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (ХХБХ)-ын "Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч" системд 27 арга хэмжээний хэрэгжилт, бусад мэдээллийг оруулж, Үндэсний хорооны гишүүдийн уялдаа холбоог хангаж 79 хувийг 4 хувиар нэмэгдүүлж, хэрэгжилтийг 83.02 хувьд хүргэсэн. https://reformtracker.org/site/dashbord/66e577a1f5f38fcda70e3918?page=Dashboard<br><br>-Уг системд өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 78 хэрэглэгч бүртгэгдсэнээс 44 гаалийн байгууллагын хэрэглэгч идэвхтэй ажиллаж, 43 үүрэг даалгаврыг уг програмын дагуу бүртгэж, хэрэгжилтийг хангаж, худалдааг хөнгөвчлөхтэй холбоотой 11 мэдээллийг оруулж, олон улсад Монголын туршлагыг түгээсэн үр дүнд хүрсэн. Өнөөдрийн 729 удаа өөрчлөлт хийж, 8,265 удаа уг системд хэрэглэгчид хандалт хийсэн нь Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны үйл ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулахад дэмжлэг болсон.<br><br>-ДХБ-ын ХХХ-ийн хэрэгжилт, Меркатор хөтөлбөрийн дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтээр ДГБ-ын "Худалдааг хөнгөвчлөх хөгжлийн загварын үнэлгээ"-ий матрицийн дагуу үнэлэхд 57 хувийг 23.7 хувиар нэмэгдүүлж 80.7 хувьд хүрч, "Дийлэнх арга хэмжээг хэрэгжүүлсэн" буюу 3 дугаар түвшинд хүрсэн үр дүнтэй байна. | | |
| 2 | 1.2.Гаалийн хяналтад эрсдэл тооцох ажлын хэрэгжилтийг хангах | Гаалийн хяналтын "Ногоон", "Улбар шар" төлөвт сонгогдож, бүрдүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>Нэг. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор макро, микро түвшний 62 судалгааг хийж гүйцэтгэсэн:<br>-Гадаад худалдааны орчны судалгаа (2018-2024 он); | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хийгдсэн мэдүүлгийн тооны өсөлт | | | -Гаалийн харилцаанд оролцогчдын хууль сахилтыг тодорхойлох зорилгоор 2024 оны импортын гаалийн бүрдүүлэлтэд хийсэн судалгаа (150 ААНБ, 149 иргэний жагсаалтыг гаргаж 2025.01.21, 02-1/320 тоотыг Татварын ерөнхий газарт хүргүүлж, үр дүнгээр 133 шалгуур үзүүлэлтийг ЭУП-д оруулсан);<br>-Нефтийн бүтээгдэхүүний судалгаа 2019-2024 он;<br>-Гаалийн хяналтын төлөвийн мэдээ 2024 он;<br>-Эрсдэлийн шалгуурын судалгаа 2024 он;<br>-Шалгалтын үр дүнгийн саналд хийсэн судалгаа 2023-2024 он;<br>-Хоёрдмол зориулалттай бараа (dual-use goods)-ны судалгаа;<br>-Бэлэн мөнгөний хяналт цэсэнд бүртгэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ, 2024 он;<br>-Зорчигчийн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл дүн шинжилгээ, 2024 он;<br>-СЯ-д “Гаалийн байгууллагын ерөнхий гүйцэтгэл” 1995-2024 он;<br>-СЯ-д “Гүйцэтгэлийн шинжилгээ” 2005-2024 он;<br>-СЯ-д “Гүйцэтгэлийн дэлгэрэнгүй” 2018-2024 он (ААН, иргэнээр);<br>-Татварын нэхэмжлэл дахин үүсгэж, импортын гаалийн үнийг бууруулсан болон өсгөсөн гаалийн бүрдүүлэлтэд дүн шинжилгээ;<br>-УИХ-ын 2023.05.30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд “Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацааг 72 цагт хүргэж бууруулна” гэсэн заалтын биелэлтэд тооцох аргачлалыг;<br>-Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах 25 ААН-ийн судалгаа (2025.02.18,01800/39 БДШГ-т хүргүүлсэн);<br>-Кайс программ-Эрсдэлийн удирдлага-Зорчигч онилох модуль-Бэлэн мөнгөний хяналт цэсэнд бүртгэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ;<br>-Гаалийн бүрдүүлэлтийн 2024 оны импортын бүрдүүлэлтийн дүн шинжилгээ;<br>-Цахим худалдааны судалгаа;<br>-Улс хоорондын шуудан илгээмжийн эрсдэлийн судалгаа;<br>-Эрсдэлийн шалгуурын судалгаа гэх мэт.<br>-"Монгол Улсын ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа болон агаарын тээврийн зорчигчийн дагалдах ачаанд тавих гаалийн хяналтыг ахисан түвшинд хүргэх төсөл”-д хамрагдах хүсэлтийг МТГ-тай хамтран 2023 онд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-д хүргүүлж, 2023, 2024 онд Техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийж уг төсөл 2025-2028 онд 5.6 сая ам. долларын өртөгтэй хэрэгжихээр болсон ба Хэлэлцээрийн протоколд Сангийн сайд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын ерөнхийлөгчтэй 2025.06.26-нд гарын үсэг зурахаар төлөвлөж байна.<br>-Монголын Гаалийн байгууллага БНСУ-ын “Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам”-ны “Хиймэл оюунд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар Монголын Гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төсөл”-д хамрагдах хүсэлтээ илэрхийлснээр БНСУ-ын Мэдээллийн технологийн консерцум (Data Innovator For a Better World B2EN Co.,Ltd) төслийг 2025-2026 онд хэрэгжүүлэхээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болж, хамтран ажиллах төлөвлөгөөнд гарын үсэг зурж, Сангийн яамаар уламжлуулан цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр ажиллаж байна.<br>Хоёр. БДШГ-тай дараах байдлаар хамтран ажилласан:<br>-БДШГ-т "ААН-ийн хууль сахилт, эрсдэлийн шалгуурын ерөнхий ойлголт", "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг нөхөн бичихэд гарсан алдаа болон хэрхэн нөхөн бичих талаар илтгэл бэлтгэж, арга зүйн зөвлөмж өгч, Эрсдэлийн удирдлагын программыг шинэчлэн хөгжүүлэх төслийн талаар мэдээлэл өгч, хамтарсан уулзалт хийж, эрсдэлд суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр санал солилцсон.<br>-Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдсан 71 ААН-д эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, эрсдэлийн удирдлагын программд оруулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан.<br>Гурав. Татварын ерөнхий газартай хамтарсан эрсдэл тооцох чиглэлээр 4 удаа уулзалт хийж, дараах мэдээллийг хүргүүлж, 518 иргэн, ААН-ийн хууль сахилтыг тодорхойлсон:<br>-Монгол Улсын 2024 оны импортод барааны тоо, нэр төрөл, статистик дүн, татварын дүнгээр хамгийн их хувь эзэлсэн 150 ААН, байгууллага, 149 иргэн (2025.01.21, 02-1/1/320);<br>-Хууль бус худалдаатай тэмцэх (2025.03.14, 02-1/1/1033) хүрээнд дотоодын зах зээлд алт, мөнгөн эдлэл худалдаалдаг иргэн;<br>-БНХАУ-ын ГЕГ-аас Итгэмжлэгдсэн Аж Ахуйн Нэгжийн эрх олгосон компанитай гадаад худалдаа эрхэлдэг Монгол талын хүлээн авагч 218 ААН.<br>Хүрсэн түвшин*:*<br>1.Эрсдэлийн шалгуурыг нэмэгдүүлсэн байдал:<br>-Тайлант хугацаанд нийт 587 эрсдэлийн шалгуур боловсруулж, Эрсдэлийн удирдлагын программд оруулсан. Бараанд хийх шалгалтаас чөлөөлөх нийт 342 эрдэлийн шалгуурыг боловсруулсан: "Зөвшөөрөгдсөн шалгуур" 268, "Үл хамаарах" шалгуурт 74 эрсдэлийн шалгуурыг программд оруулсан. Санамсаргүй сонголтын хувь хэмжээг 2024 оны импортын гаалийн бүрдүүлэлтийн судалгаанд үндэслэн 2025.01.30-ны өдөр өөрчилсөн.<br>2.Эхний хагас жил нийт 482,080 гаалийн бүрдүүлэлт хийгдсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7%-аар буурсан үзүүлэлттэй байна. (Импорт 2024/192,957, экспорт 2024/289,123):<br>-Импортын гаалийн бүрдүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 192,957 буюу 5 хувиар өссөн (2024/183,966), экспортын гаалийн бүрдүүлэлт 289,123 буюу 13%-аар буурсан үзүүүлэлттэй байна (2024/333,391).<br>-Нийт гаалийн бүрдүүлэлтийн бараанд хийх шалгалтаас 60% чөлөөлөгдөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3%-аар буурсан байна.<br>-Импортын гаалийн хяналтын төлөв: Ногоон төлөвт 3,890 (2%), улбар шар төлөвт 30,306 (16%) буюу бараанд хийх шалгалтаас 18%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үеэс **2%-аар өсч**, гадаад худалдааны эргэлтийг түргэсгэн, төсвийн орлогын шуурхай бүрдүүлж (26% буюу 748.6 тэрбум төгрөг), худалдаанд зарцуулах цаг хугацаа зардлыг бууруулсан. | | |

-<u>Экспортын гаалийн хяналтын төлөв:</u> Ногоон төлөвт 70,022 (25%), улбар шар төлөвт 192,261 (66%), бараанд хийх шалгалтаас 91%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үеэс **2%-аар өссөн.** Үүний үр дүнд 1.7 тэрбум ам.долларын экспортын барааг түргэн шуурхай нэвтрүүлсэн.
Шалтгаан, нөхцөл:
-Экспорт 13%-аар буурсан;
-Эрсдэлийн удирдлагын программд нийт 1,842 эрсдэлийн шалгуур ажиллаж байна. Үүнээс: Импортын эм, эмийн зүйл, хүнсний бараа, хоёрдмол зориулалттай бараа, лабораторийн шинжилгээнд заавал хамруулах бараа, худалдааны луйвар гаргах магадлал бүхий бараа болон тарифын бус хязгаарлалттай барааны шалгуур нэмэгдсэн.

*Хүснэгт 1. Эрсдэлийн удирдлагын программын шалгуур 2025.06.10-ны байдлаар*

| **Эрсдэлийн шалгуур** | **Экспорт** | | **Импорт** | |
|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Хувь** | **Тоо** | **Хувь** |
| Заавал шалгах | 287 | 67% | 531 | 38% |
| Зөвшөөрөгдсөн | 26 | 6% | 373 | 26% |
| Үл хамаарах | 17 | 4% | 225 | 16% |
| Өндөр | 97 | 23% | 286 | 20% |
| Дүн | 427 | 100% | 1,415 | 100% |
| Нийт шалгуурын тоо | 1,842 | | | |

*Хүснэгт 2. Импортын "Заавал шалгах" болон "Өндөр эрсдэл"-ийн нийт 817 шалгуурын задаргаа (Улаан төлөв)*

| **Шалгуурын эх сурвалж** | **Шалгуурын тоонд эзлэх хувь** |
|---|---|
| Олон улсын гэрээ, конвенц | 10.5% |
| Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, ГЕГ-ын даргын тушаал (тарифын бус хязгаарлалттай барааны хяналт (цацрагын хяналт, хүнсний аюулгүй байдал, стратегийн хоёрдмол зориулалттай бараа, эмийн хяналт, химийн бодис гэх мэт), лаборатори) | 59% |
| Барааны ангилал, үнэлгээ | 29.8% |
| БДШ | 0.7% |
| Дүн | 100% |

-Энэ хууль тогтоомж бүрэн биелэхэд 2-5 жилийн дараа Гаалийн байгууллага хилийн болон гүний гаалийн хяналтын бүсэд ямар ч бараанд шалгалт хийхгүй улсын хилээр нэвтрүүлнэ. Бодит байдалд Гаалийн байгууллагын тарифын бус хязгаарлалттай бараанд хяналт тавих чиг үүргээ биелүүлж чадахгүйд хүргэж байна. Иймд энэ шалгуурыг импорт, экспортоор тусад нь тайлагнах саналыг ХШҮДАГ-т 01800/71, ДХАБт 01800/118 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн.

-Эдгээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах нь биднээс шалтгаалахгүй тул эрсдэлд суурилсан гаалийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулахын тулд дараах ажлыг тайлант хугацаанд гүйцэтгэсэн:

-"Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө"-ний Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх зорилтын хүрээнд Гаалийн хяналтын "Ногоон", "Улбар шар" төлөвт сонгогдож бүрдүүлэлт хийгдсэн барааны гаалийн мэдүүлгийн тоог 2025 онд 0.08, 2026 онд 0.1, 2027 онд 0.12, 2028 онд 0.15 хувиар өсгөхөөр шалгуурыг оруулсан. Өөрөөр хэлбэл 2028 он гэхэд бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хувийг жил бүр нэг хувиар нэмэгдүүлж 68-д хүргэхээр тусгасан.

-Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тогтоолын бидний хувьд өөрчлөх боломжгүй тул нэн тэргүүнд эрсдэлийг бууруулахын тулд жил бүр бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хувийг нэг хувь гэж "Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө"-нд тусгасан. Энэ талаар СЯ-ны Дотоод аудит, хяналт шинжилгээний үнэлгээний хэлтсийн даргатай 2025 оны хоёрдугаар улиралд 2 удаа уулзаж, шалгуурыг өөрчлөр, төрөлжүүлэх, экспорт, импортоор салган одоогийн зөвхөн "Мэдүүлгийн тоо"-оор гаргаж байгаа шалгуурыг:

-Барааны бичлэгийн тоо,

-Статистик дүн,

-Гаалийн болон бусад татвар,

-Улаан төлөвт шалгаснаар илэрсэн зөрчлийн тоо,

-Улбар шар, ногоон төлөвт шалгасан бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмнэлт зэргээр ялгаатай гаргах,

-Зорчигчийн хяналт, Улс хоорондын шуудан илгээмжид хяналт гэж төрөлжүүлж оруулах саналаа илэрхийлсэн.

-Эрсдэлийн удирдлагын программ хангамж 2009 оноос хойш шинэчлэгдээгүй тул орчин үеийн системийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамрагдах саналын 2019 оноос эхлүүлж БНСУ-ын КОЙКА-ийн буцалтгүй тусламжаар Монгол Улсын ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа болон агаарын тээврийн зорчигчийн дагалдах ачаанд тавих гаалийн хяналтыг сайжруулах" төсөл 2025-2028 онд хэрэгжихээр болсон. Төслийн ажиллах зарчмыг ЗДАС-ийн Гадаад төсөл, хөтөлбөр талбарт байршуулсан.

-Шалгуур үзүүлэлтийг экспорт, импортоор тусдаа гаргах саналыг СЯ-аас "Гаалийн ерөнхий газрын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн тайлан"-д зөрүүгийн шинжилгээ хийлгэх хүсэлт, тайлбарыг ХШҮДАГ-т 01800/71, ДХАБт 01800/118 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн.

2."Эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ": Эрсдэлийг бууруулах чиглэлээр 62 макро болон микро судалгаа хийсэн. Судалгааны үр дүн болон ГЕГ-ын БЦТ, БДШГ, харьяа гаалийн газар, хороод, ТЕГ-тай хамтран ажиллаж, КАИС-ийн Эрсдэлийн удирдлагын программд тайланд хугацаанд нийт 587 эрсдэлийн шалгуур боловсруулж, батлуулан, оруулсан.

-Эрсдэлийн удирдлагад суурилсан үр дүнгээр БДШГ-т 36 ААН-ийн мэдээллийг хүргүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажилласан. БДШГ-аас 2025.01.11-

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ний өдрийн 01/32, 01-6/12, 01-6/18 дотоод зурвасаар ирүүлсэн бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдсан 71 ААН-д эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, эрсдэлийн удирдлагын программд оруулсан.<br>-Гаалийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газар хамтарсан эрсдэл тооцож, 518 хуулийн этгээдийн хууль сахилтыг тодорхойлж 391 аж ахуйн нэгж, иргэний бизнес скоринг хийж, холбогдох эрсдэлийн шалгуурт оруулж (175 ААН, иргэн: 2025.02.03, 218: №07/348; 218 ААН, иргэн: 2025.06.07, 218: №07/1342; 2025.05.26, №07/1528), хууль сахиулах болон хууль ёсны худалдааг хөнгөвчлөх боломжийг бүрдүүлсэн.<br>Тайлант хугацаанд зорчигчийн мэдээллийн санд 112 зорчигч бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн. Нийт 2,047 зорчигчийг шалгаж, 42 удаагийн хууль бус үйлдлийг илрүүлж, хуулийн дагуу шийдвэрлэсэн | | |
| 3 | 1.3.Гаалийн хилээр гаргах барааны бичиг баримтын бүрдүүлэлтийг Бүрдүүлэлтийн цахим төвд үе шаттайгаар төвлөрүүлэх | Хэрэгжилтийн зэрэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулж, үйл ажиллагааг хялбарчлах, уялдуулах замаар худалдааг хөнгөвчлөх, гаалийн үйл ажиллагааг цахимжуулж, хилийн гаалийн байгууллагын ажлын ачааллыг бууруулах, гаалийн байгууллагын хэмжээнд хийгдэж буй бичиг баримтын шалгалтыг нэг цэгт төвлөрүүлэх зорилгоор ЧХОУНБГГ, УХШИГГ, СЭГГ, БӨГГ, УВГГ, ХӨГХ, ЗАГХ-нд хийгдэж байгаа экспортын барааны бичиг баримтын шалгалтын ачааллыг судалсан. Энэхүү судалгааг 2025 оны 1 дүгээр сарын байдлаар гаргахад:<br>-ЧХОУНБГГ-т 258 мэдүүлгээр экспортын бүрдүүлэлт хийгдсэнээс 186 бүрдүүлэлт нь 100 горимоор;<br>-СЭГГ-т 239 мэдүүлгээр экспортын бүрдүүлэлт хийгдсэнээс 56 бүрдүүлэлт нь 100 горимоор;<br>-БӨГГ-т 65 мэдүүлгээр экспортын бүрдүүлэлт хийгдсэнээс 11 бүрдүүлэлт нь 100 горимоор;<br>-УВГГ-т экспортын 5 бүрдүүлэлт;<br>-УХШИГГ-т 192 мэдүүлгээр экспортын бүрдүүлэлт хийгдсэнээс 142 бүрдүүлэлт нь 100 горимоор буюу нийтдээ 759 бүрдүүлэлтийн 401 бүрдүүлэлт нь гаалийн хилээр бүрмөсөн гаргах 100 горимоор хийгдсэн байсан.<br>ГЕГ-ын дэргэдэх БЦТ-д харьяа 7 гаалийн газар, хороонд хийгдэж буй экспортын барааны бүрдүүлэлтийг горим харгалзахгүйгээр төвлөрүүлбэл сард 401 мэдүүлэг буюу 1 өдөрт ойролцоогоор 13 мэдүүлэгт бичиг баримтын шалгалт хийх ажил нэмэгдэх тооцоолол гарсан нь тус төвийн ажлын ачаалалд төдийлэн их нөлөөлөхгүй гэсэн дүгнэлтэд хүргэсэн.<br>Иймд ХБГ-аас 2025.02.04-ний өдөр ГЕГ-ын БЦТ, МТГ-тай хамтарсан уулзалт зохион байгуулж ЧХОУНБГГ, УХШИГГ, СЭГГ, БӨГГ, УВГГ, ХӨГХ, ЗАГХ-д хийж буй экспортын барааны бичиг баримтын шалгалтыг 2025.02.17-ны өдрөөс эхлэн горим харгалзахгүйгээр тус төвд төвлөрүүлэх шийдвэрийг гаргаж 2025.02.04-ний өдөр:<br>-ГЕГ-ын дэргэдэх БЦТ-д 01101/102;<br>-ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 01101/103 дугаартай дотоод зурвас;<br>-харьяа 7 гаалийн газар, хорооны дарга нарт 02-1/572 дугаартай албан бичгээр бэлтгэл ажлыг хангах чиглэлийг тус тус хүргүүлэн хяналт тавьж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:** | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ЧХОУНБГГ, УХШИГГ, СЭГГ, БӨГГ, УВГГ, ХӨГХ, ЗАГХ-ны экспортын бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалтыг 2025.02.17-ны өдрөөс эхлэн горим харгалзахгүйгээр ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд төвлөрүүлсэн. | | |
| 4 | 1.4.Татварын албанаас CAIS-т ирүүлсэн мэдээллийг үндэслэн гадаад жуулчны бараанд тавих хяналтыг сайжруулах | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 445 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээрх журмын 2.4. 2.4.1, 2.4.2-т Гаалийн байгууллага гадаадын жуулчны худалдан авалтад төлсөн албан татварыг буцаан олгох харилцаанд оролцохдоо энэ журмын 2.3.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд буцаан олголтын хүсэлтийг хянан, баталгаажуулахаар, 2.4.1-д заасны дагуу хянан, баталгаажуулсан талаарх мэдээллийг гаалийн системээр дамжуулан татварын нэгдсэн системд тухай бүр мэдэгдэх чиг үүрэгтэй оролцох зохицуулалттай.<br>Мөн дээрх журмын 3.8-д гаалийн улсын байцаагч нь энэ журмын 3.7-д заасан эрсдэлтэй нөхцөл үүсэж, гадаадын жуулчны ачаа, тээшинд тулган баталгаажуулалт хийж, гадаадын жуулчны гаргасан хүсэлт хууль тогтоомжид нийцээгүй нь баталгаажсан тохиолдолд худалдан авалтад төлсөн албан татварыг буцаан олгохгүй бөгөөд энэ талаар гадаадын жуулчинд мэдэгдэж, тухайн барааны буцаан олголтыг цуцлах мэдээллийг цахимаар нэгдсэн санд илгээнэ гэж заасан.<br>Өнөөдрийн байдлаар гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-ийн Зорчигч онилох модуль->Гадаад жуулчны эрсдэлтэй барааны мэдээлэл хэсэгт ирүүлсэн мэдээлэл байхгүй.<br>Гэвч эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд шалгалтыг цаг хугацаа алдалгүйгээр хийх албан хаагч нарыг шаардлагатай ажлын байранд хуваарилах ажлыг төлөвлөх зорилгоор цахим төлбөрийн баримтын системд бүртгүүлсэн гадаадын жуулчны тоон мэдээлэл, бүртгүүлсэн баримтын тоо, үүнээс буцаан олголт авсан гадаадын жуулчны тоон мэдээллийг гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-т хүлээн авах боломжийг бүрдүүлж, програмын хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 2025.01.30-ны өдрийн 02-1/500 дугаартай албан бичгээр СМТТ УТҮГ-т хүргүүлэн, хамтран ажиллаж байна.<br>Мөн дээрх ажлын хүрээнд эрсдэлтэй гадаадын жуулчны барааг шалгах цэгийг тогтоолгохоор ЧХОУНБ-д гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа эрхэлж буй НУБИЭ ХХК-тай хамтран ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>1.Эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд шалгалтыг цаг хугацаа алдалгүйгээр хийх албан хаагч нарыг шаардлагатай ажлын байранд хуваарилах ажлыг төлөвлөх зорилгоор цахим төлбөрийн баримтын системд бүртгүүлсэн гадаадын жуулчны тоон мэдээлэл, бүртгүүлсэн баримтын тоо, үүнээс буцаан олголт авсан гадаадын жуулчны тоон мэдээллийг гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-т хүлээн авах боломжийг бүрдүүлж, програмын хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 2025.01.30-ны өдрийн 02-1/500 дугаартай албан бичгээр СМТТ УТҮГ-т хүргүүлэн, хамтран ажиллаж байна.<br>2."Гааль, татварын байгууллагын цахимжилт түүний үр нөлөө ба иргэн, хуулийн этгээдийн цахим системтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх арга зам" | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдэвт хэлэлцүүлгийг 2025.06.20-ны өдөр СЯ, АТГ, ТЕГ, СМТТ УТҮГ-тай хамтран зохион байгуулах хөтөлбөр батлуулсан. Дээрх хэлэлцүүлэгт:<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 445 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг хангаж, гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS системд шаардлагатай мэдээллийг ирүүлэх асуудлыг танилцуулж хэлэлцүүлнэ. Үүний үр дүнд СМТТ УТҮГ, ГЕГ, ТЕГ, НУБИЭ ХХК зэрэг олон байгууллагууд хамтарч хийх дээрх ажлыг хэрэгжүүлнэ. | | |
| 5 | 1.5.Тээврийн хэрэгслийг рентгенээр шалгасан дүрс зургийг ОХУ-ын ХГА-тай солилцох шинэ нөхцөл, боломжийг судлах | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>ОХУ-ын ХГА-ны Монгол дахь төлөөлөгч Чагдуров Алексей Викторовичтэй 2025.05.26-ны өдөр ХБГ, ГХАХ, ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нар уулзалт зохион байгуулж:<br>-талуудын экспортын гаалийн мэдүүлэг болон цахим манифест солилцохтой холбоотой асуудлаар;<br>-Алтанбулаг, Хиагт боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийг рентгенээр шалгасан дүрс зургийг ОХУ-ын ХГА-тай солилцох асуудлаар санал солилцсон.<br>Тус уулзалтаар харилцан тохиролцсоны дагуу эхний ээлжинд 2025.05.29-ний өдрийн 16:00 цагаас ОХУ-ын ХГА-ны төлөөлөгч нартай цахим уулзалт зохион байгуулж, талуудын экспортын гаалийн мэдүүлэг болон цахим манифест солилцохтой холбоотой асуудлыг үргэлжлүүлэх ажлын талаар хэлэлцсэн.<br>Рентгены дүрс зургийг солилцох асуудлаар 2025.05.28-2025.06.04-ний өдрүүдэд ОХУ-ын ИСБ-А компаниас Улаанбаатар хотод ирж гаалийн байгууллагын албан хаагч нарт онол, дадлагын хичээл заасан багшаас зөвлөгөө авч санал солилцсон.<br>Харин рентгенээр шалгасан дүрс зургийг ОХУ-ын ХГА-тай солилцох асуудлыг 2025 онд зохион байгуулагдах Монгол Улсын ГЕГ-ын Хяналт, бүрдүүлэлтийн газар болон ОХУ-ын ХГА-ны Сибирийн гаалийн газар, Алс дорнодын гаалийн газар хоорондын хилийн холбоо баригч дарга нарын уулзалтаар хэлэлцэхээр ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дээрх ажлын хүрээнд ГЕГ-ын МТГ-аас гаалийн байгууллагад хяналтын зорилгоор ашиглаж байгаа рентгены дата мэдээллийг хадгалах, боловсруулалт хийх зориулалттай сервер тоног төхөөрөмжийн судалгааг хийж, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | 01.01-06.10 | 90 |
| 6 | 1.6.Гадаад худалдаа эрхлэгчид барааны ангиллын кодын талаар мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>1.Монгол Улсын хуулийн дагуу гаалийн албан татвараас чөлөөлөгдөх спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэл нийт 602 бараа, эрчим хүчний төслийн татвар төлөх хугацааг сунган импортлох 1603 бараа, нийт 2205 нэр төрлийн барааны ангиллын кодыг тодорхойлж, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж ажилласан.<br>2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2024 оны хууль, ЗГ-ын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 240 тотгоолыг хэрэгжүүлэх зорилгоор оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн албан татвараас чөлөөлөх БТКУС-ийн дагуу кодолсон жагсаалт Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн. БАҮХ-ээс | 01.01-06.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох чиглэл авахаар ХХААХҮЯ-нд 95 2025.01.20-ны өдрийн 02/282 тоот албан бичгийг хүргүүлж тус яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Оёдлын салбарын нэгдсэн холбооны төлөөлөл, БАУХ, ТОГ-тай хамтарсан уулзалт зохион байгуулж ажиллав. Нэгдсэн холбоогоор дамжуулан яамны албан бичгээр оёдлын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийг үйлдвэрлэлийн салбар, кодын дагуу тодорхойлж ирүүлдэг болсон нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, ААН, иргэдэд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах боломж бүрдүүллээ.<br>3.www.gaali.mn сайтад оруулсан Тайлбар бичгийн 2017 оны Боть 1 болон 3-ийг 2022 оны нэмэлт, өөрчлөлтүүдийг тусган орчуулж, орчуулгыг нэгтгэн хянах, ижилтгэх ажлуудыг хийж байна. БТКУС-ийн конвенц болон хавсралтын орчуулгыг баталгаажуулахаар 2025.06.03-ны өдрийн 02/2349 тоот албан бичгийг файлын хамт ГХЯ-нд хүргүүлсэн<br>**Хүрсэн түвшин**:<br>1.Тайлант хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлөгдөх спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэл нийт 602, эрчим хүчний төслийн татвар төлөх хугацааг сунган импортлох 1603, нийт 2205 нэр төрлийн барааны ангиллын кодыг тодорхойлж, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж ажилласан.<br>2.Тайлант хугацаанд үндэсний кодод нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн үндэслэл, шаардлага гараагүй.<br>3.УСХ-ны шийдвэрүүдээс сонгон Зүйл 20.08, 20.09, 21.06, 22.02, 24.04-ийн нийт 55 шийдвэрийг орчуулан CAIS програмын УСХ-ны шийдвэрийн санд оруулсан.<br>4.Платформын туршилтыг хийж үзэхэд тухайн бараа ангилагдах санал болгож байгаа кодууд гарахаас гадна хамааралгүй ангиллын кодууд гарч байсан тул энэ талаарх үр дүнг МТГ-ын ГУАБ Н.Мөнхзулд файлаар хүргүүлсэн. Мөн 2024 онд ангиллын код тодорхойлуулсан улсын чанартай томоохон 6 төслийн хүрээнд импортлох 4850 барааны бичиглэл, кодын мэдээллээр сан үүсгэн платформыг туршихаар файлыг хүргүүлсэн.<br>5.БТКУС-ийн конвенц, Тайлбар дүрэм, конвенцийн хавсралт болох жагсаалтын 2022 оны хувилбарыг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлүүлэх хэвлэлийн эх нийт 465 нүүр хуудсыг бэлтгэж дуусган ХХ-т дотоод зурвасаар, СЯ, УИХ-ын Тамгийн газар, ГХЯ-нд тус тус албан бичгээр хүргүүлсэн.<br>6.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах 4 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, 2 аж ахуйн нэгж, байгууллагын ангиллын кодын тайлбар, тодруулга авах хүсэлт, 2 газар, хороо, 3 зохион байгуулалтын бүтцийн нэгжээс ирүүлсэн, нийт 31 барааны ангиллын кодын талаарх хүсэлтийг шийдвэрлэж, зөвлөгөө өгч ажилласан.<br>7.ГУБ-ийн мэргэшүүлэх болон ГБМ-ий анхан, давтан сургалтуудад барааны ангиллын чиглэлээр нийт 16 цагийн хичээл заах, чиглэл, зөвлөмж өгч ажиллалаа. Мөн ДГБ-аас 05-р сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулсан “Уялдуулсан систем болон ангиллын урьдчилсан шийдвэр” сэдэвт үндэсний хэмжээний сургалтын бэлтгэл ажлыг хангах болон экспертүүдээс ирүүлсэн 11 хичээлийн танилцуулга материал нийт 512 слайдыг орчуулан бэлтгэснээс гадна хичээлийн үеэр аман орчуулга хийсэн. Уг сургалтад зарим зохион байгуулалтын бүтцийн нэгж, БЦТ болон 5 харьяа гаалийн газрын нийт 28 гаалийн улсын байцаагч хамрагдаж барааны ангиллын мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дээрх арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд "Гааль зөвшөөрөв" төлвөөс барааны ангилалтай холбоотой буцааж засварласан бичлэгийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар буурсан байна. | | |
| 7 | 1.7.Зарим барааны гаалийн үнийн хяналтыг цахимжуулах ажлыг өргөжүүлэх | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | - | 50% | Биелэлт:<br>Экспортын төмрийн хүдэр болон баяжмал, зэсийн хүдэр болон баяжмалыг биржийн гэрээтэй тохиолдолд системээс автоматаар шалгаж, баталгаажуулах програмын саналыг МТГ-т 2025.04.03-ны өдрийн 02-2/140 дотоод зурвасаар хүргүүлсэн. 2. “Зарим нэр төрлийн барааны гаалийн үнийг системээс шалгах заавар”-ыг ГЕГ-ын даргын 2024.12.31-ний өдрийн А/739 дүгээр тушаалаар батлуулсан. Тус зааврын дагуу 2025.01.01-ээс Toyota Prius, Aqia, Sai, 2025.06.07-ны өдрөөс Alphard, Vellfire, Lexus LX250 маркийн автомашинууд дээр холбогдох судалгааг хийж, CAIS системд шалгуурыг оруулан, үнийн хяналтыг цахимжуулсан. 3. 2025.01.01-нээс Aqua, Sai маркийн 2 машин, 2025.06.07-оос Alphard, Velfire, Lexus LX250 маркийн 3 автомашины 128 шалгуурыг системд оруулж баталгаажуулсан. Ингэснээр нийт 6 маркийн автомашиныг системээс автоматаар хянаж, 2025 оны 06 сарын 10-ны өдрийн байдлаар Япон улсаас импортолсон 53,046 автомашины 6056 машин буюу 11.4%-ийг системээс хянаж баталгаажуулсан байна. | 01.01-06.10 | 90 |
| 8 | 1.8.Гаалийн үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг цахимжуулах | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>Үнийн мэдээллийн санг цахимаар бүрдүүлэх 2 програмын саналыг боловсруулж, МТГ-т хүргүүлэн, програмыг туршилтаар нэвтрүүлээд байна. 2. Системээс гаалийн үнийг хянаж баталгаажуулсан мэдүүлгийг ҮМС-тай холбох програм, ангиллын хэмжих нэгж кг-аар илэрхийлэгдэх барааг 9 үзүүлэлтээр системд 57,926 шалгуур үзүүлэлтийг бүртгэж, ҮМС-г автоматаар бүрдүүлэх програмыг амжилттай туршин МЗХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэж, танилцуулгыг МЗХ-ын гишүүдэд тараасан, одоогоор хуралдаагүй байна. 3. Зарим барааны гаалийн үнийг системээс шалгаж, баталгаажуулах програмыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор Гаалийн ерөнхий газрын 2025.01.22-ны өдрийн “Журамд нэмэлт оруулах тухай” А/17, А/18 дугаар тушаалуудыг батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. 4. Нийт 6 маркийн автомашиныг системээс автоматаар хянаж, 2025 оны 06 сарын 10-ны өдрийн байдлаар Япон улсаас импортолсон 6056 автомашины үнэ, мөн 29 бүлэг барааны 2737 барааны үнэ “Баталгаажсан үнийн сан”- д автоматаар бүртгэгдсэн байна. | 01.01-06.10 | 95 |
| 9 | 1.9.Цахим худалдаанд тавих гаалийн хяналт шалгалтыг хялбарчлах зорилгоор цахим мэдээлэл солилцох технологи ажиллагааг нэвтрүүлэх | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>Улс хоорондын шуудан илгээмжийн хяналтыг сайжруулах зорилгоор илгээмжийн мэдээллийг хүлээн авах гаалийн байгууллагын нээлттэй сервисыг 2024 оны 10 сараас шинээр гаргаж, нэвтрүүлсэн. Өнөөдрийн байдлаар ХХЗХ-оос олгосон шуудангийн тусгай зөвшөөрөлтэй 35 ААН-ийн ашиглаж буй мэдээллийн системийг тус ААН-үүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу гаалийн байгууллагын мэдээллийн системтэй холбосон. Үүний үр дүнд улс хоорондын шуудан илгээмжийг рентгенээр шалгахаас өмнө илгээмжийн мэдээллийг урьдчилан авч “YES”, “NO” төлөвт оруулах үйлдлийг хийхдээ дагалдах бичиг баримтуудтай нэгбүрчлэн тулгаж, цаг алдахгүй.<br>Цаашид улс хоорондын шуудан илгээмжээр илгээгдэж байгаа цахим худалдааны барааны хяналтыг сайжруулах зорилгоор цахимаар солилцож буй мэдээллийг | 01.01 06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжруулах чиглэлээр ГЕГ-ын дэргэдэх МТГ болон ХХЗХ-оос олгосон шуудангийн тусгай зөвшөөрөлтэй ААН-тэй хамтран ажиллаж байна.<br>Мөн ГЕГ-ын удирдлагаас ОУВС-ийн багтай 2025.06.24-ний өдөр хийх уулзалтын хэлэлцэх асуудалд цахим худалдааны барааны хяналттай холбоотой асуудлыг тусгуулан, санал солилцохоор ажиллаж байна.<br>Хил дамнасан цахим худалдааны бараа улс хоорондын шуудангийн илгээмжээр илгээж байгаа илгээмжийн нэгэн адил ХХЗХ-оос олгосон шуудангийн илгээмжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ААН-ээр дамжиж улсын хилээр нэвтэрдэг.<br>Иймд Монгол Улсад хүлээн авагчтай БНХАУ-ын TEMU цахим дэлгүүрээс захиалсан барааны тээвэрлэлт 2024 оны 11 дүгээр сараас эхэлсэнтэй холбогдуулан нийт 107 удаагийн тээвэрлэлтээр улсын хилээр оруулсан 350000 гаруй хүлээн авагчийн 49 сая орчим юанийн үнийн дүнтэй бараанд гаалийн байгууллага хяналт тавьж ажилласан мэдээлэлд үндэслэн хил дамнасан цахим худалдааны хяналтыг сайжруулж, шалгалтад зарцуулах хугацааг бууруулах, цахим худалдааны барааг хүлээн авагч нарт нь хугацаа алдалгүй хүргэхийн тулд Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцүүлэн манай улсын ХХЗХ-оос олгосон шуудангийн илгээмжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ААН-ээр тээвэрлүүлэн, БНХАУ-ын хилийн боомтын тусгай гарцаар нэвтрүүлж, зориулалтын гаалийн хяналтын бүсэд гаалийн хяналтад оруулах боломжийг бүрдүүлэн хамтарч ажиллах хүсэлтийг 2025.05.05-ны өдрийн 02/1838 дугаартай албан бичгээр Марин нью пост ХХК-д хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>1.ХХЗХ-оос олгосон шуудангийн тусгай зөвшөөрөлтэй 35 ААН-ийн ашиглаж буй мэдээллийн системийг тус ААН-үүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу гаалийн байгууллагын мэдээллийн системтэй холбосон.<br>2.Монгол Улсад хүлээн авагчтай БНХАУ-ын TEMU цахим дэлгүүрээс захиалсан барааг манай улсын ХХЗХ-оос олгосон шуудангийн илгээмжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ААН-ээр тээвэрлүүлэн, БНХАУ-ын хилийн боомтын тусгай гарцаар нэвтрүүлж, зориулалтын гаалийн хяналтын бүсэд гаалийн хяналтад оруулах боломжийг бүрдүүлэн хамтарч ажиллах хүсэлтийг 2025.05.05-ны өдрийн 02/1838 дугаартай албан бичгээр Марин нью пост ХХК-д хүргүүлсэн. | | |
| 10 | 1.10.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрлийн системд гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох сунгах | Хэрэгжилтийн эрэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт**:<br>1.ГЕГ-ын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг батлуулсан. Журмыг гаалийн газар, хороод болон МГЗМХ-гоор дамжуулж гаалийн зуучлагч, ГБМ нарт хүргэсэн. Мөн https://customs.gov.mn/-д байршуулсан. Журам батлагдсантай холбогдуулан 2025.01.17-ны өдөр ГЕГ БЦТ, УБГГ, ЗҮГГ, БЦТ, СЭГГ, БӨГГ, ГСГГ, ЧХОУНБГГ, ХАГГ, ХОГГ-тай онлайн хурлаар журмын танилцуулга, гаалийн зуучлагч байгууллага, ГБМ-д хяналт тавьж ажиллах болон журмын зүйл, заалт дахь агуулгыг нэг мөр ойлгох талаар чиглэл, зөвлөмжөөр хангасан. Мөн 2025 онд зохион байгуулагдсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний 3 удаагийн анхан шат, 3 удаагийн давтан сургалтад нийт 356 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд журмын танилцуулга, хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар 12 цагийн хичээл заасан.<br>2.СМТТ УТҮГ-т тусгай зөвшөөрлийн цахим системд оруулах засвар, өөрчлөлтийн талаар 2025.01.31-ний өдрийн 02-2.1/548 дугаартай албан бичиг хүргүүлсэн, | 01.01-06.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | асуудлыг шийдвэрлэх | | | | 2025.03.12-нд онлайн уулзалтыг хийж, програмын даалгаврын талаар хэлэлцсэн. 2025.05.08,15,22-ний өдрүүдэд онлайнаар туршилт хийсэн. ГБМ-ий өөрийн үнэлгээний хуудасны үзүүлэлт 18 байсныг 9 болгосон засварыг хийж гүйцэтгэсэн. Гаалийн зуучлагчийн баталгааны хуудсыг хүсэлт гаргахдаа Бүрдүүлэх материал хэсэгт PDF-ээр хавсаргаж өгөх байдлаар оруулахаар, эрсдлийн сангийн 200 сая төгрөгийг санхүүгийн тайлангийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө хэсгийн үзүүлэлтийг татаж харуулахаар хийсэн. Тайланд 200 сая төгрөг байхгүй бол банкны баталгааг PDF-ээр хавсаргаж оруулахаар програмд өөрчлөлтийг оруулсан. Зуучлагчийн үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэх хуудасыг 3.4 дүгээр улиралд хөгжүүлэлтийг хийхээр болсон.<br>3.Тусгай зөвшөөрлийн цахим системд 3 ААН-ийн хүсэлтийг хянаж, Сангийн сайдын тушаалаар зөвшөөрөл олгосон. 2ААН зөвшөөрөл хүссэн, 1ААН-ийн хугацаа сунгуулах хүсэлтийг хянаж, Сангийн яаманд хүргүүлсэн.<br>4.2025 оны тайлант үед 1318903 бичлэг бүхий бараанд нийт 480610 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн. 44266 мэдүүлгийг засварт буцаасан бөгөөд үүний 34394 ГБМ-ээс засварт буцаасан, үүнээс мэдүүлэгчээс шалтгаалахгүй засвар буцаалт 7716 хасаад нийт 26678 алдаатай мэдүүлэг байна. Нийт бичлэгийн тоонд харьцуулахад 2,0% байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1%-иар өссөн дүнтэй байгаа ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад статистик дүнд нөлөөлөх алдаанууд буурсан дүнтэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>1.ГЕГ-ын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг батлуулсан. Журмыг гаалийн газар, хороод болон МГЗМХ-гоор дамжуулж гаалийн зуучлагч, ГБМ нарт хүргэсэн. Мөн https://customs.gov.mn/-д байршуулсан. Журам батлагдсантай холбогдуулан 2025.01.17-ны өдөр ГЕГ БЦТ, УБГГ, ЗҮГГ, БЦТ, СЭГГ, БӨГГ, ГСГГ, ЧХОУНБГГ, ХАГГ, ХОГГ-тай онлайн хурлаар журмын танилцуулга, гаалийн зуучлагч байгууллага, ГБМ-д хяналт тавьж ажиллах болон журмын зүйл, заалт дахь агуулгыг нэг мөр ойлгох талаар чиглэл, зөвлөмжөөр хангасан. Мөн 2025 онд зохион байгуулагдсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний 3 удаагийн анхан шат, 3 удаагийн давтан сургалтад нийт 356 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд журмын танилцуулга, хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар 12 цагийн хичээл заасан.<br>2.СМТТ УТҮГ-т тусгай зөвшөөрлийн цахим системд оруулах засвар, өөрчлөлтийн талаар 2025.01.31-ний өдрийн 02-2.1/548 дугаартай албан бичиг хүргүүлсэн, 2025.03.12-нд онлайн уулзалтыг хийж, програмын даалгаврын талаар хэлэлцсэн. 2025.05.08,15,22-ны өдрүүдэд онлайнаар туршилт хийсэн. ГБМ-ий өөрийн үнэлгээний хуудасны үзүүлэлт 18 байсныг 9 болгосон засварыг хийж гүйцэтгэсэн. Гаалийн зуучлагчийн баталгааны хуудсыг хүсэлт гаргахдаа Бүрдүүлэх материал хэсэгт PDF-ээр хавсаргаж өгөх байдлаар оруулахаар, эрсдлийн сангийн 200 сая төгрөгийг санхүүгийн тайлангийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө хэсгийн үзүүлэлтийг татаж харуулахаар хийсэн. Тайланд 200 сая төгрөг байхгүй бол банкны баталгааг PDF-ээр хавсаргаж оруулахаар програмд өөрчлөлтийг оруулсан. Зуучлагчийн үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэх хуудасыг 3.4 дүгээр улиралд хөгжүүлэлтийг хийхээр болсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3.Тусгай зөвшөөрлийн цахим системд 3 ААН-ийн хүсэлтийг хянаж, Сангийн сайдын тушаалаар зөвшөөрөл олгосон. 2ААН зөвшөөрөл хүссэн, 1ААН-ийн хугацаа сунгуулах хүсэлтийг хянаж, Сангийн яаманд хүргүүлсэн.<br>4.2025 оны тайлант үед 1318903 бичлэг бүхий бараанд нийт 480610 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн. 44266 мэдүүлгийг засварт буцаасан бөгөөд үүний 34394 ГБМ-ээс засварт буцаасан, үүнээс мэдүүлэгчээс шалтгаалахгүй засвар буцаалт 7716 хасаад нийт 26678 алдаатай мэдүүлэг байна. Нийт бичлэгийн тоонд харьцуулахад 2,0% байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1%-иар өссөн дүнтэй байгаа ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад статистик дүнд нөлөөлөх алдаанууд буурсан дүнтэй байна. | | |
| 11 | 1.13.Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэх | Хэрэгжилтийн зэрэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>Хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг RFID-ээр нэвтрүүлэхдээ эрсдэлийн удирдлагын програмд урьдчилж оруулсан шалгуурын дагуу шалгах системийг Замын-Үүд боомтын зорчигчийн терминалд 3 сарын хугацаатай туршилтаар нэвтрүүлэх асуудлыг ГЕГ-ын 2025.05.21-ний өдрийн МЗХ-д танилцуулж, шийдвэрлүүлсэн. Мөн МТГ-т:<br>-Ухаалаг гарцын зааварт нийцүүлэн экспорт, импортын бараа ачих, буулгах, гаалийн хяналт, шалгалт хийх зориулалтаар ААН-ийн тогтоолгосон ГХБ-үүдэд суурилуулсан RFID тоног төхөөрөмжүүдийг гаалийн байгууллагын системтэй холбох, CAIS, CEPS, Smartgate.ecustoms.mn системд хийгдэх шаардлагатай программын даалгаврыг боловсруулж 2025.01.07-ны өдрийн 01101/13 дугаартай дотоод зурвасаар, мөн 2025.05.28-ны өдрийн 01101/337 дугаартай дотоод зурвасаар дээрх ажлыг эрчимжүүлэх талаар;<br>-Эрсдэлд суурилсан зарчимд үндэслэн гаалийн хяналт, шалгалтаас чөлөөлөгдсөн (ногоон) тээврийн хэрэгсэл, зорчигчийн автобусанд зориулсан гарцыг smartgate.ecustoms.mn систем дээр хэрэглэгч өөрөө буюу ХШ хариуцсан ГУАБ тохируулдаг байх нэмэлт өөрчлөлт хийлгэхээр 2025.06.04-ний өдрийн 01101/365 дугаартай дотоод зурвас тус тус хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>CAIS-т ЭУХ-ээс боловсруулсан шалгуур үзүүлэлтийн дагуу ухаалаг гарцын системд тээврийн хэрэгсэлд эрсдэл тооцох тооцооллыг оруулж, туршилтаар 2025.05.15-ны өдрийн 14:00 цагт Замын-Үүд боомтын зорчигчийн терминалд нэвтрүүлсэнээр 18478 тээврийн хэрэгсэл улаан, 3572 тээврийн хэрэгсэл ногоон төлөвт сонгогдсон байна. | 01.01-06.10 | 90 |
| 12 | 1.14.Гадаад худалдааны статистик мэдээллийг түгээх, боловсронгуй болгох | Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгчийн тоо болон цахим лавлагаа авсан | - | 50% | **Биелэлт:**<br>Нэг.Гадаад худалдааны статистик мэдээлэл гаргах ажлын хүрээнд:<br>ҮСХ, ГЕГ-ын дарга нарын 2015 оны А/14, А/15 хамтарсан тушаалаар батлагдсан "Барааны экспорт, импортыг бүртгэх, статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг үндэслэн гадаад худалдааны 2024 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэл, 2025 оны 1-5 дугаар сарын барааны статистик мэдээлэл, динамик статистик мэдээллийг боловсруулж www.gaali.mn сайтад байршуулсан.<br>Хоёр. Захиргааны статистик мэдээллийг гаргах ажлын хүрээнд<br>1.ГЕГ-ын даргын 2023 оны 12-р сарын 20-ны өдрийн А/676 тушаалаар шинэчлэгдэж 24 хавсралтаар тухайн журамд заасан аргачлалын дагуу сар бүрийн 15-ны дотор сар бүр нийт 13 хавсралтыг ГЕГ-ын газар хэлтсүүдээс авч бусад 8 хавсралтыг тус | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэглэгчийн нийт тоо, гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын програмыг сайжруулсан модулийн тоо | | | хэлтсийн статистикч ГУБ Tableu болон CAIS-аас мэдээлэл боловсруулалтыг хийж ажилласан. Нийт 24 хавсралтаар тайлбар танилцуулгын хамтаар гаргаж 2024 оны 12-р сар (дараа оны 1-р сард гардаг), 2025 оны 1, 2, 3, 4-р сарын захиргааны статистикийн мэдээллийг, дүн шинжилгээний хамт /15 хуудас/ CERP-ын "Статистик" талбарт байршуулсан.<br>2."Захиргааны статистик мэдээлэл"-ийг зөвхөн гаалийн байгууллагын хэмжээнд ашигладаг бөгөөд CERP-д байршуулдаг. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 667 хэрэглэгч буюу cerp.ecustoms.mn-д бүртгэлтэй гаалийн байгууллагын албан хаагч нар уншиж танилцан дотоод хэрэгцээндээ ашигласан байна. Өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар өссөн байна.<br>Гурав. Гадаад худалдааны статистик, лавлагаа мэдээлэл хүлээн авсан хэрэглэгч хандалт:<br>1.Гаалийн цахим үйлчилгээний систем www.gaali.mn -ны Статистик цонхонд Гадаад худалдааны барааны статистик мэдээллийг сар бүр байршуулж ажилласанаар 2024 оны 6 дугаар сарын 31-ний байдлаар 649 аж ахуй нэгж, иргэн экспорт, импортын статистик мэдээллийг авсан хандалт хийсэн бол 2025 оны 6 дугаар сарын 12-ны байдлаар 3,180 аж ахуй нэгж, иргэн, CERP системээс 147 хэрэглэгч авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2531 хэрэглэгчээр 4 дахин буюу 412 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2.Гаалийн цахим үйлчилгээний системээр https://gaali.mn/: 2024 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 6801 /ААН-4245, иргэн 2556/ аж ахуй нэгж, иргэн гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа авсан бол 2025 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 23420 /ААН-5768, иргэн 17652/ аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 244%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: "Аствишн" ХХК/<br>Дөрөв. Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын програмыг 3 чиглэлээр сайжруулж ажилласан.<br>**Хүрсэн түвшин**:<br>-Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгчийн тоо/хандалт/ нэгжийн зүгээс програм, системийн сайжруулалт, утсаар болон албан бичгээр www.gaali.mn системээс хандаж мэдээлэл авах боломжтой талаар арга хэмжээ авч ажилласны үр дүнд өмнөх оны мөн үеэс 412 хувиар, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 244 хувиар өссөн.<br>-Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын програмыг 3 чиглэлээр сайжруулнаар үр дүн гарсан. | | |
| 13 | 1.15.**Гадаад орны гаалийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд гадаад худалдааны мэдээлэл солилцох үйл** | Хэрэгжилтийн зэрэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>1.ОХУ, БНХАУ-д гадаад худалдааны 2024 оны жилийн эцсийн мэдээлэл гасантай холбоотойгоор зэрэгцүүлэлт хийх мэдээллийг Гадаад хамтын ажиллагааны хэлтэст цахим сүлжээгээр 2025.04.22-ны өдөр СДШХ-ийн 01600/200, 01600/201 дугаар дотоод зурвасаар дамжуулан хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>2.ГХАХ-ны хэлтсээр дамжуулан БНХАУ, ОХУ-аас мэдээллээ ирүүлэх талаар албан хүсэлт тавьсны үндсэн дээр БНХАУ-аас 2025.03.25-ны өдөр файлаар, ОХУ-ын ЭСЯ-аас 2024 оны мэдээллийг 2025.05.27 дискээр ирүүлсэн. /Эдгээр мэдээлэл нь урьдчилсан байдлаар тул зэрэгцүүлэлт хийх боломжгүй./<br>**Хүрсэн түвшин:** | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг хөгжүүлэх | | | | Худалдааны түнш орнуудтай гадаад худалдааны мэдээллийг цахим хэлбэрээр солилцсон. | | |
| 14 | 1.17.Гаалийн төв болон салбар лабораторийг үндэсний болон олон улсын итгэмжлэлд хамруулах | Гаалийн төв болон салбар лаборато-риуд нь Үндэсний болон олон улсын итгэмжлэлд хамрагдсан байна. | - | 50% | **Биелэлт.**<br>1.2025.06.03-04-ний өдрүүдэд Үндэсний итгэмжлэлийн төв (MNAS) болон Ази номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APAC)-ын хамтарсан “Гаалийн төв болон салбар лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, хар тамхи мансууруулах бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, эзрмэл, сүлжмэл материалийн шинжилгээний чиглэлээр давтан итгэмжлүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт, ургамал хорио цээрийн шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөх” үнэлгээнд амжилттай хамрагдав. Урьдчилсан дүнгээр 2 үл тохиролтойгоор тэнцсэн бөгөөд уг үл тохиролыг залруулан, баритжуулж, “Үл тохиролыг залруулсан тухай тайлан” (23 хуудас )-г ГТЛ-ийн 2025.6.13-ны өдрийн 02-2.3/534 дугаар албан бичгээр Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлсэн болно. 2025.6.16-ны өдрийн ҮИТ-ийн техникийн хорооны хурлаар эцсийн шийдвэр гарсан.<br>2.Гаалийн төв лаборатори нь уул уурхайн хүдэр баяжмал, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний чиглэлээр БНХАУ-ын Итгэмжлэлийн байгууллага болох CNAS (China National Accreditation Service for Conformity Assessment)-ийн давтан үнэлгээнд 2025.04.18-21-ний өдрүүдэд амжилттай хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин**:<br>1.ГТЛ нь эрдэс түүхий эд, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, хар тамхи мансууруулах бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, эзрмэл, сүлжмэл материалийн шинжилгээний чиглэлээр Үндэсний итгэмжлэлийн эрхээ амжилттай сунгасан.<br>2.ГТЛ нь хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт болон ургамал, хорио цээрийн шинжилгээний шинэ арга, аргачлал нэвтрүүлэн, хэрэгжүүлж ажилласнаар итгэмжлэлийн хүрээг амжилттай өргөтгөв.<br>3.Гаалийн 12 салбар лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, хар тамхи мансууруулах бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, эзрмэл, сүлжмэл материал, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт болон ургамал, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр ГТЛ-ийн хамт итгэмжлүүлэх ажлыг амжилттай хийж гүйцэтгэв.<br>ГТЛ нь уул уурхайн хүдэр баяжмал, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний чиглэлээр БНХАУ-ын итгэмжлэлийн эрхээ амжилттай сунгав. | 01.01-06.10 | 100 |
| 15 | 1.18.Гаалийн хяналтад эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлэх | Хэрэгжилтийн зэрэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>1.ГЕГ-ын харьяа 16 гаалийн газар, 3 гаалийн хорооноос 13 гаалийн газар 3 хороонд эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч ажиллахаар бүтэц орон тоо батлагдсанаас 2025 оны эхний хагас жилийн байдлаар 11 гаалийн газар 2 хороонд 33 эрэлч нохойг гаалийн хяналт шалгалтад тогтмол ашиглаж байна. Эрэлч нохойн сургалтын төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эрэлч нохой ашиглалтыг | 01.01 06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэгдүүлэх, зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд гаалийн газар хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагч нараас эрэлч нохой ашиглалтын мэдээг сар бүр нэгтгэн авч байна. Эрэлч нохдыг гаалийн хяналт шалгалтад ашигласан байдал: 1-р сард Тээврийн хэрэгсэл-3,507.80 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 9,596.15 2-р сард Тээврийн хэрэгсэл- 8,522 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 63,224.65 3-р сард Тээврийн хэрэгсэл- 10,614 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 49,789 4-р сард Тээврийн хэрэгсэл- 6,372 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 71,760.7 5-р сард Тээврийн хэрэгсэл- 8,290 100 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 73,871 2025 оны 1-р сарын 1 ний өдрөөс 6-р сарын 17 ний өдөр хүртэлх хугацаанд эрэлч нохой ашиглан нийт 20 удаагийн зөрчил илрүүлснээс эрүүгийн 3 зөрчил байна. Үүнд:<br>1.ЗҮГГ- 5 зөрчил;<br>2.СЭГГ- 10 зөрчил;<br>3.УХШИГГ 3 зөрчил;<br>4.ШХГГ- 1 зөрчил;<br>5.ДОГГ- 1 зөрчил тус тус илрүүлэн ажилласан. 2024 оны эхний хагас жилтэй харьцуулахад 42.86% өссөн байна. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03-р сарын 27-ны өдрийн №А/190 тоот тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал” 6.1.12 ын дагуу гаалийн газар хороодын эрэлч нохой ашиглалтад үнэлгээг хийж Захиргаа, дотоод ажлын системийн төлөвлөгөө цэсийн нэгжийн биелэлт дэд цэсийн биелэлт дүгнэх (нэгж) хэсэгт тайлбар зөвлөмжийн хамт байрлуулсан.<br>2.Гаалийн байгууллагад ажиллаж байгаа эрэлч нохойн ашиглалтын мэдээг нэгтгэх, мэдээллийн санг үүсгэх зорилгоор ГЕГ-ын ХБГ, МТГ, ЭНСТ хамтран гаалийн ЗДАС-д /https://cerp.ecustoms.mn/-ийн хилийн хөдөлгөөний мэдээ дэд цэсэд эрэлч нохой ашиглалт нэртэй баганыг шинээр нэмж тээврийн хэрэгсэл орсон гарсан, гар тээш, дагалдах ачаа, бараа орсон гарсан, илрүүлсэн зөрчил орсон гарсан гэсэн 6 төрлийн үзүүлэлтүүдээр тоон мэдээллүүдийг нэгтгэн авдаг болсон. Хилийн хөдөлгөөний мэдээний эрэлч нохой ашиглалт хэсэгт орж байгаа мэдээллийн санд хяналт тавих зорилгоор ГЕГ-ын дэргэдэх ЭНСТ-ийн даргын баталсан жижүүрийн хуваарийн дагуу тус төвийн ГУАБ 1, ГУБ 4 нийт 5 албан хаагч тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>Хилийн хөдөлгөөний мэдээ цэсээр дамжуулан авч байгаа тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн гаалийн хяналт шалгалтад эрэлч нохойн эзлэх хувийн жинг тодорхойлон ажиллаж байна. Хувийн жинг дараах томьёог ашиглан тодорхойлж байна. E=(E1+E2)/2 E= эрэлч нохой ашиглалт E1= Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа, тээврийн хэрэгсэлд хийсэн шалгалтын тоонд эрэлч нохойг ашиглаж хийсэн шалгалтын хувийн жин. E2=Гаалийн хяналтаар илрүүлсэн зөрчлийн тоонд эрэлч нохойг ашиглаж илрүүлсэн зөрчлийн эзлэх хувь. Гаалийн байгууллагын 2025 оны эхний 5 сарын гаалийн хяналт шалгалтад эрэлч нохой ашиглалтын хувийн жин.<br>1-р сард E1- 0,28% E2- 0.38 E= 0,66%;<br>2-р сард E1- 1,47% E2- 1,81% E= 1,64%;<br>3-р сард E1- 0,77% E2- 0,78% E= 0,78%;<br>4-р сард E1- 1.05% E2- 1.54% E= 1.29%;<br>05-р сард E1- 1.27% E2- 1,27% E= 1,27%. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 1.19.Байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэх | Гаалийн байгууллагын гадаад, дотоод үйл ажиллагаа стандартад нийцсэн байдал /өссөн дүнгээр/<br><br>ИААН-ийн хөтөлбөрт хамруулсан ААН-ийн тоо /тоогоор/ | - | 50% | **Биелэлт:**<br>1.Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг Олон улсын стандартын байгууллагын Эрсдэлийн удирдлагын зарчим ба стандарт ISO 31000:2018, Монгол Улсын Эрсдэлийн удирдлагын стандарт 31000:2020 баримт бичигт үндэслэн хэрэгжүүлэх чиглэлээр харьяа гаалийн газар, хороод, Ёс зүйн дэд хороог мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан.<br>2.Дэлхийн худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байлгах тухай багц стандартын "Гааль-Бизнесийн түншлэл" тулгуур баганын хүрээнд ИААН хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх:<br>Гааль-Бизнесийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор хууль сахилт сайн үндэсний үйлдвэрлэгч 15 аж ахуйн нэгжид итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрт хамрагдах урилгыг хүргүүлж, хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан ААН-ийг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган, 9 ААН-ийн 30 албан хаагчийг оролцуулсан сургалт зохион байгуулсан. Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (AEO)-ийн гаалийн бүрдүүлэлт хамгийн түрүүнд болон өөр өнгөөр бусад бүрдүүлэлтээс ялгарч харагдах байдлаар программд нэмэлт, өөрчлөлт оруулж, Гаалийн байгууллагын цахим системд "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан орны AEO хөтөлбөрт хамрагдсан ААН-ийн мэдээллийг нэр, хаяг, ялган таних код буюу AEO код, итгэмжлэл олгосон огноо гэсэн" 4 үзүүлэлтээр бүртгэх; Ялган таних код буюу AEO кодоор аж ахуйн нэгжийг таньж зохих хөнгөлөлтийг эдлүүлэх (дараалал харгалзахгүйгээр хяналт шалгалт хийх, 3 сард нэг удаа лабораторийн шинжилгээнд хамруулах) программын өөрчлөлтийг оруулсан. Гаалийн байгууллагын https://customs.gov.mn/ веб сайт болон Монголын гааль фэйсбүүк хуудсанд дараах мэдээллийг нийтэлсэн.<br>3. Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх чиглэлээр БНХАУ, БНСУ, Хонг-Конг, ОХУ, Тажикистан Улсын гаалийн байгууллагатай ГХАХ-ээр уламжлуулан 23 цахим захидал солилцож, 7 уулзалтыг зохион байгуулж, хамтран ажилласан. Монгол, БНХАУ-ын гаалийн байгууллага Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (AEO)-ийг Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг эрчимжүүлэх цахим уулзалт зохион байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор хэрэгжүүлсэн.<br>**Хүрсэн түвшин**:<br>1.Эрсдэлийн удирдлагыг олон улсын стандарт (ISO 31000:2018)-ын дагуу хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж Гаалийн байгууллагын Авлигын эрсдэлийн зураглал гаргах аргачлалыг Ёс зүйн дэд хороо, Сургалтын төвтэй хамтран боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглан, Авлигатай тэмцэх газар, Ёс зүйн хороонд хүргүүлж, ГЗДАС-ийн Ёс зүйн дэд хороо талбарт байршуулж, Гаалийн байгууллагын Ёс зүйн эрсдэлийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлж, сайн туршлагыг Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академитэй хуваалцсан.<br>2.ИААН хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний үйлдвэрлэл эрхлэгч 15 ААН-д урилга хүргүүлж, хөтөлбөрийг сурталчлан, 5 ААН-д удирдамжийг батлуулж, 2 ААН-ийн ажлын байрны үнэлгээ, баталгаажуулалтыг хийж, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>Гаалийн төв лабораторид ИААН-ийн барааны дээжийг дараалал харгалзахгүй магадлан шинжилгээнд хамруулах, сорилтын дүн, дүгнэлт гаргах үйл ажиллагааг аль | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болох богино хугацаанд гаргах, магадлан шинжилгээний дүгнэлтийн хугацааг 3 сар хүчинтэй байхаар зохицуулалт хийж худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлу, ГТЛ-оос магадлан шинжилгээний дүгнэлтийг 3 сар хүчинтэй байхаар гаргах болсноор бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулсан.<br>Мал эмнэлгийн ерөнхий газарт "ИААН-ийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж чиг үүргийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэж, хялбарчлах арга замын шийдлийг олох" талаар хамтын ажиллагааг эхлүүлсэн.<br>3.Гадаад орны гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хүрээнд БНХАУ-ын ГЕГ-тай байгуулсан хэлэлцээрийг албан ёсоор эхлүүлж, хоёр орны Гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан ААН 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс талуудын импортын бүрдүүлэлтэд хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлсэн. ОХУ, Беларусь, Хонг-Конгийн Гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлж эхэлсэн. | | |
| 17 | 1.20.Цахим нэг цонхны системийг бий болгох ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | 50% | **Биелэлт:**<br>ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.08.10-ны өдрийн А/138 дугаартай тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ХБГ, ХЦХ, МТГ-ын албан хаагч нар ажиллаж байна. Тус ажлын хэсэг 2025 оны эхний 5 сард хуралдаагүй.<br>Монгол улсад гадаад худалдааны харилцааг зохицуулах тарифын бус хязгаарлалтын аргаас бүртгэлийн хэлбэрийг хамгийн өргөн хэрэглэдэг бөгөөд улсын хилээр нэвтрүүлэх тодорхой нэрийн бараанд тусгай зөвшөөрөл болон бүртгэл олгох замаар төрөөс хяналт тавьж байна.<br>Иймд гадаад худалдаатай холбоотой дээрх зөвшөөрлийг олгодог байгууллагууд цахим нэг цонх мэдээллийн системийг ашиглаж, олон төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дор төвлөрүүлсэнээр гаалийн байгууллагын үйл ажиллагааг хялбарчилж, гадаад худалдаанд оролцогч нарт чирэгдэлгүй орчин бүрдүүлэхээр ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд иргэний зориулалтаар хилээр оруулах галт зэвсэгт Цагдаагийн байгууллагаас олгодог зөвшөөрлийг CAIS-т гаалийн мэдүүлэгт цахимаар татах асуудлаар ХЗДХЯ-ны мэргэжилтэн Энх-Эрдэнэ, СМТТ УТҮГ, ЦЕГ-ын төлөөлөлтэй 2025.02.11, 2025.04.29 өдөр уулзалт зохион байгуулж, дараах ажлуудыг хэрэгжүүлж байна:<br>1.ХЗДХЯ болон ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвөөс олгож буй тусгай зөвшөөрөл, лицензийг цахимаар олгохоор программын даалгавар боловсруулах;<br>2.Гаалийн байгууллагын цахим системтэй холбох, ингэхдээ БТКУС-ийн ангиллын кодоор "заавал" татахгүйгээр, эхний байдлаар шаардлагатай тохиолдолд олгосон зөвшөөрлийг мэдүүлэгт татаж оруулж байх;<br>3.Цаашид Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, галт зэвсэг, дагалдах хэрэгслийн ялгааг нарийн тодорхойлох боломжтой болсны дараа "заавал" татаж оруулдаг болгохоор програмд өөрчлөлт оруулах.<br>**Хүрсэн түвшин:** | 01.01-06.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1.Зөвшөөрлийн хуулийн дагуу ХЗДХЯ, ЦЕГ-аас олгодог галт зэвсэг, сум, адилтгах хэрэгсэл, дагалдах хэрэгсэлд олгодог тусгай зөвшөөрлийг цахимаар олгох болон гаалийн байгууллагын CAIS-т гаалийн мэдүүлэгт цахимаар татах интеграци хийж, харилцан мэдээлэл солилцох, хяналт бүртгэлийг сайжруулах ажлыг эхлүүлсэн.<br>2.Галт зэвсэгийн зөвшөөрлийг гаалийн мэдүүлэгт цахимаар татах хөгжүүлэлт хийгдэж байгаатай холбогдуулан галт зэвсэг, адилтгах хэрэгсэл, дагалдах хэрэгслийн БТКУС-ын ангиллын кодны жагсаалтыг СМТТ УТҮГ-т хүргүүлсэн.<br>3.ХХААХҮЯ-ныхарьяа Хөдөө аж ахуйн биржээс хэрэгжүүлж буй цахим нэг цонхны систем /export.mofa.gov.mn/-д гаалийн хорио цээрийн apqs.gaali.mn системийг холбож ААН-ийн экспортод зарцуулах цаг, хугацааг багасгасан. БНХАУ-ын ГЕГ-тай мах, махан бүтээгдэхүүний экспортын мэдээг Нэг цонхны үйлчилгээний хүрээнд цахимаар солилцож хамтран ажиллаж, уул уурхайн бус гаралтай экспортыг нэмэгдүүлэх үр дүнд хүрсэн.<br>4.ГХЯ, ЭЗХЯ, СЯ-нд Цахим нэг цонхыг нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийн тайланд дэлгэрэнгүй тусган, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан. ГЕГ-ын даргын 2025.06.12-ны албан бичгээр Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн бусад арга хэмжээний хамт хүргүүлсэн. Цахим нэг цонхыг нэвтрүүлж, ДХБ-д мэдэгдэл хүргүүлэх хугацаа 2025 он тул энэ арга хэмжээ хэрэгжсэнээр Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт 100 хувьд хүрнэ. | | |
| | | | | | Зорилт 2.Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах | | |
| 18 | 2.5.Нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлын өөрийн үнэлгээний аргачлалыг боловсруулж, батлуулан, үнэлгээ хийх | Үнэлгээний аргачлал, өөрийн үнэлгээ хийгдсэн боомтын тоо,<br>Үнэлгээний тайлан | - | 50% | **Биелэлт:**<br>ДЭМБ-ын хөндлөнгийн шинжээч нарын үнэлгээний аргачлалд үндэслэн үндэсний хэмжээний хилийн боомтуудыг үнэлэх асуумж боловсруулан 2025.04.25-ны өдөр хэлтсийн албан хаагчдаар, 2025.04.28-ны өдөр ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн мэргэжилтнүүдийн түвшинд хэлэлцүүлэг тус тус зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн дүнд гарсан санал зөвлөмжийг тусган нийт 95 асуулт бүхий асуумжийг нэгтгэж, 2025.05.07-ны өдрийн 02-1,2/1889, 1890, 1891, 1892, 1893 дугаартай үнэлгээ хийх тухай албан бичгээр үнэлгээ хийгдэх 5 боомт дахь гаалийн газрууд /ХГГ, ЗҮГГ, ЧХОУНБГГ, СЭГГ, ЗАГХ/ руу илгээж, Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний 1.2.3 дугаар заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Ханги, Замын-Үүд, Чингис хаан боомтуудад “Хилийн нэвтрэх цэгийн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл явдлыг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ”-г ХӨСҮТ, ЗӨСҮТ, ОБЕГ, ДЭМБ-тай хамтран 2025.05.09-ний өдрөөс 2025.06.10-ны өдрийг хүртэл зохион байгуулж, Ханги боомт 64,5 хувь буюу 3-р түвшинд, Замын-Үүд боомт 77,3 хувь, Чингис хаан боомт 70,3 хувь буюу тус тус 4-р түвшинд үнэлэгдэж. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавхийн хувьд Ханги боомт нь чадавхижиж байгаа, Замын-Үүд, Чингис хаан боомтууд нь чадавхитай боомт гэж үнэлэгдсэн. Үнэлгээний дүнд цаашид тухайн боомтын чадавхийг сайжруулах зөвлөмжийг боловсруулж, Замын-Үүд боомтод сум орон нутгийн түвшинд 3, боомтын хэмжээнд 2, гаалийн газрын хэмжээнд 6, Ханги боомтод сум орон нутгийн түвшинд 3, боомтын хэмжээнд 4, гаалийн газрын хэмжээнд 8, заалт бүхий зөвлөмжийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 02/ 2347, 02/2348 | 01.10<br>06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоот албан бичгээр тус тус хүргүүлж ажиллалаа.СЭГГ, ЗАГХ-д 2025.06.16, 2025.06.23-ны өдрөөс үнэлгээ хийгдэнэ.<br>**Хүрсэн түвшин:**<br>Үндэсний хэмжээний “Хилийн нэвтрэх цэгт нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл явдлыг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ хийх” асуумжтай болсноор цаашид сайжруулан ашиглах, боомтын чадавхийг үнэлэх боломжтой болсон. Үнэлгээ хийгдсэн боомтуудын хувьд чадавхжиж байгаа болон чадавхжсан гэж үнэлэгдсэн ба цаашид нийт боомтын чадавхийг үнэлж, суурь үзүүлэлттэй болох бөгөөд шат дараалласан арга хэмжээ авч боомтуудын чадавхийг дээшлүүлэх боломжтой болсон. | | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 19 | 3.1.Улсын төсвийн гаалийн орлогыг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй бүрдүүлэх | Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт төгрөгөөр, хувиар | - | 50% | Нэг.Сангийн сайдын “Төсвийн хуваарь батлах тухай” 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 40 дүгээр тушаалыг үндэслэн ГЕГ-ын даргын 2025-02-19-ний А/91 тоот /Хавсралт№3/ “Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарь батлах тухай” тушаалыг батлуулан гаалийн газар хороодод хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.<br>1)ГЕГ-ын 2025.01.02-ны Чиглэл хүргүүлэх тухай албан тоотоор Улсын төсвийн гаалийн орлогын 1 дүгээр сарын хуваарь;<br>2)ГЕГ-ын 2025.02.04-ний 01/585 албан тоот Чиглэл хүргүүлэх тухай албан тоотоор Улсын төсвийн гаалийн орлогын 2 дугаар сарын хуваарь;<br>3)ГЕГ-ын 2025.03.07-ны 01/945 албан тоот Чиглэл хүргүүлэх тухай албан тоотоор Улсын төсвийн гаалийн орлогын 3 дугаар сарын хуваарь;<br>4)ГЕГ-ын 2025.04.08-ны 02-2/1397 албан тоотоор Ажлын чиглэл хүргүүлэх тухай Улсын төсвийн гаалийн орлогын 4 дүгээр сарын хуваарь;<br>5)ГЕГ-ын 2025.04.29-ний 02-2/1769 албан тоотоор Чиглэл хүргүүлэх тухай Улсын төсвийн гаалийн орлогын 5 дугаар сарын хуваарь;<br>6)ГЕГ-ын 2025.06.03-ны 02-2/2345 албан тоотоор Чиглэл хүргүүлэх тухай Улсын төсвийн гаалийн орлогын 6 дугаар сарын хуваарь.<br>2025 оны улсын төсвийн орлогын хуваарийг Сангийн сайдын баталсан тушаал болон ГЕГ-ын даргын баталсан хуваарийн дагуу хэрэгжүүлж байна. Уг хуваарийг бүх гаалийн газар, хороодод сар бүр ГЕГ-ын даргын болон ТОГ-ын даргын албан тоотоор хүргүүлэн, биелэлтэд нь хяналт тавьж ажилладаг. Орлогын хуваарийг гаргахдаа дараах хүчин зүйлсийг судалгааны үндсэн дээр харгалзан тооцдог.<br>Үүнд:<br>-Импортын урсгалын хэмжээ, бүтэц, улирлын хэлбэлзэл;<br>-Тээвэр, ложистикийн нөхцөл байдал - Боомтын нэвтрүүлэх хүчин чадал, цагийн хуваарь, ачаалал;<br>-Бараа, бүтээгдэхүүний шилжилт, өөрчлөлт;<br>-Тухайн гаалийн газар, хорооны сүүлийн 10 жилийн гаалийн бүрдүүлэлтийн мэдээ;<br>-Татварын орлогын гүйцэтгэл, төлөвлөлтийн хандлага.<br>Хоёр.Татварын орлогын гүйцэтгэлийн тайлбар Гаалийн байгууллага нь 2025 оны эхний 5 сарын байдлаар Улсын төсөвт 2952.1 тэрбум төгрөг төвлөрүүлэх үүрэгтэйгээс 2732.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 93.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Гаалийн болон НӨАТ-ын орлого импортын хэмжээ, бүтэц, гаалийн үнэлгээнээс шууд хамаардаг. | 01.01-06.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Импорт буурч, чингэлэгийн тоо буурсан, уул уурхайн хамаарах бараа /шатахуун/-ны импорт буурахын зэрэгцээ, БНХАУ-ын арматур, барилгын бүтээц төмрийн зах зээлийн үнэ буурснаар орлогын гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэв.<br>Гүйцэтгэл тасарсан шалтгаан, нөлөөлөл:<br>Татварын орлогын дийлэнхийг бүрдүүлдэг гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварын биелэлт нь татвартай бараа, бүтээгдэхүүний импортын хэмжээ, барааны бүтэц, гаалийн үнэлгээтэй шууд хамааралтай байдаг. Эхний 5 сарын гүйцэтгэлээр татварын орлого тасрахад дараах гадаад болон дотоод хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Гадаад улс орны эдийн засгийн савлагаа, тарифын өөрчлөлт, худалдааны тодорхой бус байдал нь манай улсын экспортод суурилсан импортод сөргөөр нөлөөлсөн.Мөн Тяньжин боомтын чингэлгийн тоо өмнөх оны мөн үеэс 1425–1500 чингэлэгээр буурч, төмөр замын тээвэрлэлт саарсан. Уул уурхайн хамааралтай тоног төхөөрөмж, машин механизмын импорт багассан.Барилгын гол нэрийн материал болох арматурын БНХАУ дахь зах зээлийн үнэ буурсан нь дотоод үнэд мөн нөлөөлж, татварын суурийг бууруулсан. Автобензин, дизель түлшний импорт тогтворгүй, хэмжээ багатай байна. Иймд уг төрлийн татварууд (ОАТ болон албан татвар) төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй.<br>Зохион байгуулалтын ажлын үр дүн:<br>Гаалийн байгууллага нь УТО-ын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч, нэмэлтээр 103.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн:<br>-Эрсдэлтэй бараа, байгууллагыг нарийвчлан судалж, хяналтыг эрчимжүүлсэн;<br>-Буруу үнэлгээ, гаалийн зөрчил, зардлын дутуу тайлагналтай холбоотой нөхцөл байдлыг засварласан;<br>-Бүрдүүлэлтийн хяналт, гүйцэтгэлийн хяналтыг давхаржуулсан;<br>-Автозамын хилийн боомт дээр суурилагдсан рентгены ашиглалтыг сайжруулж, хилээр ачаатай нэвтэрсэн барааны 90 гаруй хувийг рентгены хяналтад бүрэн хамруулсан;<br>-Гаалийн газар, хороодын гаалийн хяналтын бүс, талбай, гаалийн баталгаат агуулах зэрэгт хугацаа хэтэрсэн, гаалийн горимд байршуулаагүй бараанд тавих хяналтыг сайжруулсан;<br>-БЦТ-ийн бичиг баримт хариуцсан ГУБ нарын гаалийн үнэлгээг дахин бууруулах замаар татварын орлогыг бууруулж байгааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлд холбогдох ажлыг хийж эхэлсэн;<br>-Гаалийн бүрдүүлэлтийн түр "500" горимд байршуулсан барааны гаалийн үнийн хяналт, хугацаанд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр ХБГ, БАУХ, БЦТ-д дотоод зурвасыг хүргүүлэх зэрэг ажлуудыг хийсэн.<br>Нэг.Улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээрхи шуурхай хуралдаанд газар хороодод үүрэг даалгавар тухай бүр өгч, тодорхой ажлуудыг гүйцэтгэж ажилласан. Түүнчлэн харьяа гаалийн газар, хороодын сар бүрийн орлогын төлөвлөгөөний дүн шинжилгээг хүлээн авч нэгтгэж удирдлагад танилцуулсан.<br>Гурав.БЦТ-ийн бичиг баримт хариуцсан ГУБ нар “Бичиг баримтын шалгалт хийгдсэн” төлөвийн дараа барааны үнийг бууруулан давхар нэхэмжлэх үүсгэж, нийт 7192 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдүүлэгт 247.8 тэрбум төгрөгийн орлогын алдагдал үүсгэсэн нь судалгааг хийсэн. Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна:<br>-"Давхар нэхэмжлэх" үүсгэх боломжийг Кайс системд хаах;<br>-Үнэлгээтэй холбоотой журам, зааварт нэмэлт өөрчлөлт оруулах;<br>-Гомдол, хүсэлтийг цахимаар шийдвэрлэж, системд шийдвэрийн мэдээллийг оруулах зохицуулалт хийх.<br>Эдгээр арга хэмжээ нь улсын төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Тус чиглэлээр ГЕГ-ын 2025.02.20-ны 02-2/809 албан тоотоор Хариу хүргүүлэх тухай ЗҮГГ-т танилцуулгыг хүргүүлсэн.<br>Дөрөв.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд: ГЕГ-аас газар, хороодын орлогын гүйцэтгэлийг сар бүр хянаж, татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг шахах, зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилгоор төлөвлөгөөг албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.<br>Тав.Гаалийн байгууллага нь Төсвийн орлогын гүйцэтгэлийг 7 хоног бүр мэдээлэх зорилгоор Сангийн яамны Төсвийн бодлогын газрын Орлогын хэлтэст тогтмол тайлан хүргүүлж, танилцуулж байна.Тайлагналын бүтэц дараах бүтэцтэй байна.<br>-Орлогын дүн (үндсэн болон нийт орлого);<br>-Импортын барааны бүтэц тус бүрээр гүйцэтгэл;<br>-Өмнөх 7 хоног болон өмнөх оны мөн үетэй харьцуулалт.<br>-Орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн гол хүчин зүйлүүдийн товч тайлбар. Зургаа. Сангийн сайдын 2024 оны 22 дугаар тушаал "Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах тухай" ын дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайлангийн биелэлтийг 2024 оны жилийн эцсээр гарган ГЕГ-ын 2025.01.15-ны 02/214 албан тоотоор хүргүүлсэн.<br>Хоёр.Сангийн сайдын 2025 оны 18 дугаар тушаалаар батлагдсан "Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний дагуу төлөвлөгөөний биелэлтийг СЯ-нд хүргүүлсэн. | | |
| 20 | 3.2.Өгөгдлийн дүн шинжилгээ, их өгөгдөл, хиймэл оюун ухаан зэрэг дэвшилтэт технологийг ашиглах | Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт | - | 50% | **Биелэлт:**<br>1.Гаалийн үнийн хяналт тавих, дүн шинжилгээ хийх зорилгоор МТГ-тай хамтран дашбоардаар гаргах мэдээлэлд санал өгч, дараах үзүүлэлтээр хийгдсэн:<br>1.1.Дахин нэхэмжлэх үүсгэж байгаа байдалд хийх дүн шинжилгээ:<br>-Дахин нэхэмжлэх үүсгэж татвар бууруулсан мэдүүлгийн жагсаалт,<br>-Бууруулсан татварын дүн, бараагаар,<br>-Бичиг баримтын байцаагчийн хувийн дугаараар, давтамж<br>1.2. Автомашины бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх:<br>-Гаалийн үнэ, үнэлгээний аргаар<br>-Системээс гаалийн үнийг хянаж, баталгаажуулсан мэдүүлэг, шалгуурт баригдаагүй тайлбараар<br>1.3. Үнийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийх:<br>-Үнийн мэдээлийн сангийн бичлэг, барааны кодод<br>-Үнийн мэдээллийн сан дахь үнээр гаалийн үнийг тодорхойлсон байдал Үнийн мэдээллийн санг цахимаар бүрдүүлэх програмын дагуу 85 автоматаар орсон үнийн мэдээлэл | 01.01-06.10 | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2.Хиймэл оюу ухаанд суурилсан БТКУС ийн ангиллын код санал болгох платформ http://hs.ecustoms.mn/-ын ажлын явцтай танилцан сайжруулах, магадлалын хувийг нэмэгдүүлэхээр хамтран ажилласан. Тус платформын санал болгож буй кодод хамааралгүй барааны ангиллын кодууд гарч байсан тул энэ талаарх үр дүнг МТГ-т файлаар хүргүүлсэн. Мөн 2024 онд ангиллын код тодорхойлуулсан улсын чанартай томоохон 6 төслийн хүрээнд импортлох 4850 барааны бичиглэл, кодын мэдээллээр сан үүсгэн платформыг туршихаар файлыг хүргүүлсэн.<br>3.Хиймэл оюу ухаанд суурилсан автомат хариулагч Чатбот хөгжүүлэх ажлын хүрээнд МТГ-т барааны ангилал, гаалийн үнэлгээ, гаалийн зуучлагчийн чиглэлээр нийт 58 асуулт, хариултыг бэлтгэн дотоод зурвасаар хүргүүлсэн. | | |
| 21 | 3.5.Авто зам, төмөр зам, агаарын замын тээврийн хэрэгсэл шалгах заавар боловсруулж, батлуулах | Батлуулсан эрх зүйн актын тоо | - | 50% | **Биелэлт:**<br>Авто зам, төмөр зам, агаарын замын тээврийн хэрэгсэл шалгах заавар боловсруулж, батлуулах зорилгоор:<br>-агаарын боомтоор нэвтрүүлэх онгоц, нисдэг тэрэгний хяналт, шалгалтыг сайжруулахтай холбоотой сургалтад ашиглах, мөн гаалийн хяналт, шалгалтад анхаарах асуудлыг харуулсан зураг, схем бүхий заавар, зөвлөмжийг ирүүлэх, мөн ЧХОУНБГГ-ын албан хаагч нарт онгоц, нисдэг тэрэгт гаалийн хяналт, шалгалт хийхдээ анхаарах зөвлөмж өгөх ажлын байрны сургалтыг зохион байгуулж хамтран ажиллах хүсэлтийг 2025.04.02-ны өдрийн 02-1/1318 дугаартай албан бичгээр;<br>-автозамын боомтуудаар нэвтрэх тээврийн хэрэгслийн хяналт, шалгалтыг сайжруулахтай холбоотой сургалтад ашиглах тээврийн хэрэгслийн төрөл, бүтэц, гаалийн хяналт, шалгалтад анхаарах асуудлыг харуулсан зураг, схем бүхий заавар ирүүлэх хүсэлтийг АТҮТ-д 02-1/1632 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Тээвэрлэгч байгууллагуудад ашиглагдаж буй вагонд үзлэг хийх схем, агаарын хөлөгт шалгалт хийж, тэсрэх бодис илрүүлэх үзлэгийн хуудсыг судалж, төслийг урьдчилсан байдлаар боловсруулсан. | 01.01-06.10 | 90 |
| 22 | 3.6.Хорио цээр эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын эрх зүйн орчин боловсронгуй болгох | Батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | - | 50% | **Биелэлт:**<br>1.ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын шинэчилсэн төсөлд санал өгч, ХБГ-т 2025.01.24-ний өдрийн 114 Дотоод зурвасаар, хорио цээрийн чиглэлийг дахин тусгаж, 2025.03.24-ний өдөр 288 тоот Дотоод зурвасаар ХБГ-т 23 саналыг тус тус хүргүүлсэн. "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам" /төсөл/-д хорио цээрийн хэлтсээс оруулах саналын хэлэлцүүлгийг ХБГ-тай хамтран 2025.04.17-ны өдөр зохион байгуулж, тэмдэглэлийг хөтлүүлж, нэмэлтээр тусгах саналыг ХЦХ-ийн 2025.05.07-ны өдрийн 513 тоот Дотоод зурвасаар хүргэсэн. Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний 1.2.3 дахь заалт болох "Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний болон барааны аюулгүй байдал" хэсгийг эцэслэн боловсруулж, Сангийн Сайдаар 2025.01.10-ны өдөр батлуулж, уг стратегийг хэрэгжүүлэх, аргачиллыг баталсан 2025.02.21-ний өдрийн А/64 дүгээр тушаалыг мөрдүүлж ажилласан. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага", "Тээврийн хэрэгсэлд хийгдэх халдваргүйжүүлэлтийн | 01.01 06.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | журам"-ын төслийг боловсруулж, ХХ, ХБГ-аас санал авч, байгууллагын вэб хуудаст 1 сарын хугацаатай байршуулж, Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээч, амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхийн эд бүтээгдэхүүнийг импортлогч, экспортлогч, тээвэрлэгч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан санал сонсох, мэдээлэл авах "Сонсгол"-ыг 2025.05.07-ны өдөр ХХ-тэй хамтран зохион байгууллаа. Уг сонсголд 41 иргэн, ААН-ийн төлөөлөл оролцож ЭМЯ, ЗӨСҮТ, МЭЕГ-аас санал авч саналыг журмын төсөлд тусгаж ажиллахаар шийдвэрлэн, төлөвлөгөөний дагуу МЗХ-аар оруулахаар шийдвэрлэсэн.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт заасан амьтны гоц халдварт өвчин болон ургамлын хорио цээртэй хөнөөлт организм улсын хилээр нэвтрэн тархах эрсдэл үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдал бүрдсэн үед баримтлах нийтлэг журам /дэглэм/, Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын хавсралт "Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам"-ын төслүүдийг тус тус боловсруулж, журмын төслүүдэд Мал амьтны эрүүл мэндийн асуудал, Ургамлын хорио цээрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудаас холбогдох мэргэжилтнийг оролцуулахаар 2025.06.06-ны өдөр 02-1.2/2426 тоот, 02-1.2/2427 албан бичгүүдийг хүргүүлсэн. **"**Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын удирдамж"-ийн дагуу Гаалийн тухай хуулийн төсөлд хорио цээрийн чиглэлээр хүргүүлэх саналыг хуулийн хэлтэст 2025.02.05-ын өдрийн №156 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.ГЕГ-ын даргын 2025.05.09-ний өдрийн А/176 тоот "Уулзалтад оролцуулах тухай" тушаалын дагуу МУ-ын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хооронд байгуулсан "2022 оны Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол"-ыг хэрэгжилтийг хангуулах хүрээнд ЗӨСҮТ, ХӨСҮТ-тэй хамтран, БНХАУ-ын Хөх хот, Эрээн ГГ-тай хамтран 2025.05.14-16-ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод болсон уулзалтад ГЕГ-ын ХЦХ, Замын-Үүд ГГ-ын ХЦА-ны төлөөллүүд оролцож, дээрх протоколын хэрэгжилтийн талаар Монголын талын илтгэл хэлэлцүүлэв.Уулзалтын мөрөөр 4 заалтаар /Монгол, Хятадын хилийн боомтуудын мэрэгчээр дамжих зоонозын халдварт өвчний хамтарсан тандалт, хилийн эрүүл ахуй, хорио цээрийн асуудлаар хэлэлцээр, эрдэм шинжилгээний хурал, үзүүлэх сургууль/ 2025 онд ажлыг төлөвлөж, хамтын ажилллагааны **протоколыг** үйлдэж, Хөх хотын ГГ, МУ-ын ГЕГ-ын ХЦХ, ӨМӨЗО-ны Өвчнөөс урьдчилан сэргийлэх төв, МУ-ын ЗӨСҮТ-ийн талаас баталгаажуулав.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хорио цээрийн чиглэлээр илэрч буй зөрчилд дүн шинжилгээ хийж, Хуулийн хэлтэст холбогдох хуулиудад оруулах саналыг хүргэж, "Нийтлэг журмын төсөл", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага", "Тээврийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгсэлд хийгдэх халдваргүйжүүлэлтийн журам"-төслийг боловсруулж, Гаалийн тухай хуульд хорио цээрийн чиглэлээр тусгах саналуудыг боловсруулсан. | | |
| 23 | ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчид гаалийн хяналт тавих нийтлэг журмыг шинэчлэн боловсруулсан төслийг батлуулах /3.7 үндсэн шалгуурт тусгагдаагүй/ | Батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | - | 50% | **Биелэлт:**<br>ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэх төслийг боловсруулж,ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар хороодоос 2023-2025 онд ирүүлсэн саналыг нэгтгэн, тусгаж эцэслэн боловсруулсан.<br>Журмын төслийг 2025.02.17-ны 01101/133 дугаартай дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлж хянуулан, 2025.02.18-ны 01200/64 дотоод зурвасаар хариу ирүүлсэн санал зөвлөмжийг журмын төсөлд тусгасан.<br>АТГ-с албан бичгээр болон Мөрдөгчийн мэдэгдэл хэлбэрээр "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-д гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагааны үе шат бүрт оролцож байгаа албан хаагчдыг албан тушаал бүрээр гүйцэтгэх үүргийг тодорхой зааж тусгах чиглэл өгсөн тул ирүүлсэн саналыг журмын төсөлд тусгаж, эцэслэн боловсруулсан төслийг танилцуулж, санал авах зорилгоор АТГ-т 2025.02.24-ний 02/850 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Журмын төслийг ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө эцэслэн боловсруулсан төслийг ГЕГ-ын ЗББНДБ-д танилцуулахаар 2025.03.12-ны 01101/162 дугаартай дотоод зурвасаар хүргүүлж, 8 нэгжээс ирүүлсэн саналыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төсөлд тусгасан.<br>Журмын төслийг ГЕГ-ын 2025.04.11-ний өдрийн МЗХ-д танилцуулж, хэлэлцүүлэн тус хуралдаанаас гарсан шийдвэрийг төсөлд тусгаж, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн хянуулахаар Хуулийн хэлтэст 2025.04.15-ны 01101/236 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. Хуулийн хэлтсээс 2025.04.17-ны 01200/182 дотоод зурвасаар ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу журмын төсөлд зохих үг, үсгийн алдаа, утга найруулгын давхардлыг эцэслэн нягтлан засварлаж, төслийг ГЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар тушаалын төсөл, МЗ-ийн гишүүдэд хүргүүлсэн танилцуулга, МЗХ-ны 2025.04.11-ний өдрийн шийдвэрийн хамт ГЕГ-ын даргад хүргүүлсэн. ГЕГ-ын даргаас 2025.04.29-нд журмын төслийг ГЕГ-ын ЗББНДБ-д дахин танилцуулах чиглэл өгч буцаан ирүүлсэн тул 2025.05.07-ны 01101/282 дугаартай дотоод зурвасаар ЗББНДБ-ын дарга нарт дахин хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>ЗББНДБ-ын 13 нэгжээс ирүүлсэн саналыг судалж, саналын дагуу төсөлд зарим нэмэлт өөрчлөлтийг тусгахын зэрэгцээ, зарчмын зөрүүтэй зарим саналын талаар танилцуулга бичиж, ГЕГ-ын 2025 оны 6 дугаар сарын МЗХ-д дахин танилцуулж, хэлэлцүүлэхээр бэлтгэсэн. | 01.01-06.10 | 90 |
| 24 | ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Гаалийн хилээр | Батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | - | 50% | **Биелэлт:**<br>ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар" болон тус зааврын дор дурдсан хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, эсэх талаар саналаа 2025.01.27-ны өдрийн дотор ирүүлэхийг ГЕГ-ын ЗББНДБ-д 2025.01.20-ны өдрийн 01101/59 дугаартай дотоод зурвас хүргүүлж, 13 нэгжээс ирүүлсэн саналыг нэгтгэсэн. | 01.01-06.10 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэвтрүүлэх барааны мэдүүлэг нөхөн бичих заавар, Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах зааврыг шинэчлэн боловсруулсан төслийг батлуулах /3.8 үндсэн шалгуурт тусгагдаагүй/ | | | | 2."Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар"-ын "Хоёр. Гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичих" хэсэгт заасан гаалийн мэдүүлгийг нөхөн бичих хүснэгт дэх мэдээлэл өнөөдрийн байдлаар гаалийн автоматжуулсан удирдлагын систем CAIS системд байгаа мэдээлэлтэй тохирч байгаа эсэх, нэмэлт, өөрчлөлт орсон байдлыг хүснэгт нэг бүрээр, Гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичих үед энэ хэсэгт заасан мэдээллийн хэд дэх хүснэгтийн аль үзүүлэлтүүдийг гараар нөхөн бичдэг, мөн програмаас татаж оруулдаг эсэх, тухайн хүснэгт дэх мэдээллийг тоогоор, эсхүл үсгээр илэрхийлэх зэрэг мэдээллийг гаргаж хамтран ажиллахыг ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 2025.03.11-ний 01101/160 дугаартай дотоод зурвасаар хүсэлт хүргүүлсэн.<br>3.Тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар"-ыг шинэчлэн боловсруулсан төсөлтэй танилцаж, саналаа 2025.04.15-ны дотор хариу ирүүлэхийг хүсэн ГЕГ-ын ЗББНДБ-ын дарга нарт 2025.03.27-ны 01101/185 дугаартай дотоод зурвас хүргүүлсэн. "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар"-ыг шинэчлэн боловсруулсан төсөлд ГЕГ-ын ЗББНДБ-аас 8 нэгж санал ирүүлсэн бол, 4 нэгж "саналгүй" гэсэн хариу ирүүлсэн. Харин 11 нэгжээс хариу ирүүлээгүй.<br>"Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар"-ыг шинэчлэн боловсруулсан төслийг харьяа гаалийн газар, хороодод 2025.03.27-ны 02-1/1222 албан бичгээр хүргүүлсэнд 11 гаалийн газар хорооноос санал ирүүлсэн бол 2 газар саналгүй гэсэн хариу ирүүлж, үлдсэн нэр бүхий 5 гаалийн газар, хороо хариу ирүүлээгүй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн саналыг судлан төсөлд тусган ГЕГ-ын 2025 оны 6 дугаар сарын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн. | | |
| **Зорилт 4. Соён гэгээрүүлэх** | | | | | | | |
| 25 | Зураасан код, түүнтэй адилгах кодыг гаалийн мэдүүлэгт нөхөн бичихтэй холбоотой сургалт, сурталчилгаа зохион байгуулах /4.8 үндсэн шалгуурт тусгагдаагүй/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | **Биелэлт:**<br>Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т Энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангилал болон Татварын ерөнхий хуулийн 33.4-т заасан журмын дагуу олгосон зураасан болон түүнтэй адилтгах код, нэр төрлөөр гаргахаар зохицуулсан.<br>Энэ зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Барааны зураасан код болон түүнтэй адилтгах кодыг олон улсын стандартын дагуу давхардалгүй үүсгэхтэй холбоотой асуудлаар 2025.01.31-ний өдрийн 14:00 цагт МТГ-ын ГУАБ Н.Мөнхзул, СДШХ-ийн ГУБ Нямдаваа нарын хамт Д:Ариунцэцэг, М.Батбилэг нар Дэлхийн Стандарт Нэг Монгол Нийгэмлэг ТББ-ийн захирал Ш.Цэвэлсайхантай уулзалт зохион байгуулж санал солилцсон.<br>Дээрх уулзалтын үр дүнд Дэлхийн Стандарт Нэг Монгол Нийгэмлэг ТББ-ын захирал Ш.Цэвэлсайхантай хамтран барааны зураасан код болон түүнтэй адилтгах кодыг олон улсын стандартын дагуу давхардалгүй үүсгэхтэй холбоотой асуудлаар:<br>-ГЕГ-ын БЦТ-ийн 36 албан хаагчид 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 08:00 цагт;<br>-УБГГ-ын 130 албан хаагчид 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 08:00 цагт; | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -ЧХОУНБГГ-ын 101 албан хаагчид 2025.05.20-ны өдрийн 08:00 цагт;<br>-УХШИГГ-ын 48 албан хаагчид 2025.06.04-ний өдрийн 08:00 цагт тус тус зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>-Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т Энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангилал болон Татварын ерөнхий хуулийн 33.4-т заасан журмын дагуу олгосон зураасан болон түүнтэй адилтгах код, нэр төрлөөр гаргахаар зохицуулалт нэмэгдэж орсон боловч гаалийн байгууллагын албан хаагч нарт барааны зураасан кодтой холбоотой мэдээлэл өгч, сургалтыг зохион байгуулаагүй байсан.<br>-Барааны зураасан код болон түүнтэй адилтгах кодыг олон улсын стандартын дагуу давхардалгүй үүсгэхтэй холбоотой асуудлаар гаалийн байгууллагын 315 албан хаагчид танхимын сургалт зохион байгуулсан. | | |

## Хоёр. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| УИХ, ЗАСГИЙН ГАЗАР, ЯАМ БОЛОН БУСАД АГЕНТЛАГААС БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ | | | | | | | |
| 1 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 | Монгол улсын Ерөнхий Сайдын 2024.11.18-ны өдрийн 123 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. "Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр | 3-р сарын 25-28-ы өдрүүдэд ЭЗХЯ дээр гадаад худалдааны цахим хэлэлцүүлэгт оролцож үзэл бодол байр сууриа илэрхийлсэн. | 01.01-06.10 | 100 |
| 2 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Монгол улсын Ерөнхий Сайдын 2024.10.07-ны өдрийн 72 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2004 оны 1540-р тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор стратегийн ач холбогдол бүхий зарим аюултай бараа бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдаанд хяналт тавих тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. Гаалийн байгууллагаас хуулийн төсөлтэй холбоотой холбогдох саналыг нэгтгэж тусгасан. | | |
| 3 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 | Монгол улсын Тэргүүн Шадар бөгөөд ЭЗХ Сайдын 2025.02.20-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | 02-р сарын 25-ны өдөр ЭЗХЯ дээр зохион байгуулагдсан Худалдааны тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаанд оролцсон. 02-р сарын 14-ний өдөр Чөлөөт худалдааны хэлэлцээр бүхий ажлын хэсэгт санал бодлоо илэрхийлэн оролцов. | 01.01-06.10 | 100 |
| 4 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Хүнсний хангамж аюулгүй байдлын асуудлаар уулзалт, нэвтрүүлэгт оролцон гаалийн байгууллагын байр суурийг илэрхийлэх | Хүнсний баталгаат байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хорио цээрийн хяналтын талаарх мэдээллийг холбогдох газарт хүргүүлж ажилласан. Bloomberg ТВ-д 4-р сарын 10-ны өдөр Хүнсний хувьсгал ба Хүнсний аюулгүй байдлын хяналт сэдвээр оролцож тус тус үзэл бодол байр сууриа илэрхийлсэн. | 01.01-06.10 | 100 |
| 5 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 | ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ЗГ-ын 2024 оны 181-р тогтоолоор батлагдсан "Монгол улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн ажлын хэсэг /ЭЗХЯ/ | Гаалийн үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийг гаалийн байгууллагын хэмжээнд хангуулан, 1-р улирлын биелэлтийг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн байна. Үүнд:<br>1 УИХ-ын тогтоол 5<br>2 УИХ-ын байнгын хорооны тогтоол 2<br>3 Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж 1<br>4 Засгийн газрын тогтоол 9<br>5 Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 12<br>6 Засгийн газрын албан даалгавар 2 | 01.01-06.10 | 100 |
| 6 | Аюулгүй байдлын дэд хороо | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 | НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенцийн талуудын 17 -р бага хурал зохион байгуулах дэд хорооны бүрэлдэхүүнд ажилласан байна. | Аюулгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд ажиллаж чиглэлээр хангагдсан. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Зөвлөлийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЗТХ-ийн сайдын 2021.02.26-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулагдсан "Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл"-ийн ажлын хэсэгт гишүүнээр ажилласан байх. | ажлын хэсгийн уулзалт 2025 оны 7-р сарын 7-8-ны өдрүүдэд Ази Номхон далайн бүс нутгийн агаарын тээврийг хялбаршуулах форум /FALF-2025/ үеэр зохион байгуулагдах ба тус форумд илтгэл бэлтгэн оролцохоор төлөвлөгдөн ажиллаж байна. | 01.01-06.10 | 90 |
| 8 | Зөвлөлийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн ажлын хэсэгт ажиллах | ажлын хэсгийн уулзалт 2025 оны 7-р сарын 7-8-ны өдрүүдэд Ази Номхон далайн бүс нутгийн агаарын тээврийг хялбаршуулах форум /FALF-2025/ үеэр зохион байгуулагдах ба тус форумд илтгэл бэлтгэн оролцохоор төлөвлөгдөн ажиллаж байна. | 01.01-06.10 | 90 |
| 9 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 | Монгол Улсын ЗГХЭГ-ын даргын 2023.10.30-ны өдрийн 97 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна.<br>Франц-Монголын Ураны гэрээ /Татвар санхүү/ -нд хяналт тавих ажлын хэсэгт ажилласан байна. | 1-р сарын 28-ны өдөр ЭЗХЯ дээр зохион байгуулагдсан "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр" төслийн ажлын хэсгийн хуралд оролцож санал бодолоо илэрхийлсэн болно. | 01.01-06.10 | 100 |
| 10 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Алтанбулаг, Замын-Үүд боомтод барилгын дотоод заслын материалыг хянах чиглэлээр бэхжүүлэх ажлын хэсэгт ажиллах | Импортын барилгын материалын эрүүл ахуй, чанар аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 4-р сарын 1-ний өдөр батлаж, Хүний эрхийн комисст 02/1462 тоот албан бичгээр хэрэгжилтийг явцын мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна. | 01.01-06.10 | 100 |
| 11 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 | Ерөнхий Сайдын 3-р сарын 13-ны өдрийн 46 дугаар захирамжаар байгуулагдсан "Биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах" ажлын хэсгийн гишүүн | 03-р сарын 15-ны өдөр АҮЭБЯ дээр зохион байгуулсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн хуралд оролцов. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Зөвлөлийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 | Сангийн яамны дэргэдэх хөгжлийн бэршээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн гишүүнээр ажилласан байх. | Сангийн яамны дэргэдэх хөгжлийн бэршээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн хуралд 2025 оны 1-р сарын 7-ны өдөр оролцож гаалийн байгууллагын системийн хэмжээнд хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээлэл танилцуулга хийж оролцов. | 01.01-06.10 | 100 |
| 13 | Төслийн удирдах хороонд гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 | Монгол улсын Шадар Сайдын 2025 оны 04-р сарын 18-ны өдрийн 61 дүгээр тушаалаар байгуулагдсан "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн удирдах хороонд ажиллах. | 2025 оны 05-р сарын 06-ны өдрийн 14.00 цагт Монгол улсын Шадар Сайдын ажлын алба дээр зохион байгуулсан хуралд оролцож байр сууриа илэрхийлэн ажилласан. | 01.01-06.10 | 100 |
| 15 | төслийн удирдах хороонд ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Гадаад харилцааны Сайдын 2024 оны А/81 дүгээр тушаалаар байгуулагдсан "Олон улсын худалдааг дэмжих төсөл"-ийн удирдах хорооны ажлын хэсэгт ажилласан байх. | 2-р сарын 03-ны өдөр ГХЯ дээр зохион байгуулсан Монгол Улсын Худалдааг хөгжүүлэх төсөл уулзалтад ЭУХ-ийн дарга, ахлах нартай хамт оролцож үзэл бодол байр сууриа илэрхийлсэн. | 01.01-06.10 | 100 |
| 16 | төслийн удирдах хороонд ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2025 он | Гадаад харилцааны Сайдын 2025 оны 1-р сарын 20-ны өдрийн А/02 дүгээр тушаалаар байгуулагдсан "Ази Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааны хэлэлцээр" -ийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт ажилласан байх. | Ази Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээр болон үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн талаарх анхдугаар хуралдаанд 02-р сарын 13-ны өдөр оролцсон болно. ЗТЯ-ны Далайн тээврийн захиргааны албаны холбогдох ажилтантай 1-р сарын 21-ний өдөр уулзалт зохион байгуулж санал бодлоо солилцсон. Түүнчлэн 06-р сарын 06-13 -ны өдрүүдэд Тайланд улсад зохион байгуулагдсан Ази Номхон далайн цаасгүй худалдаа арга хэмжээнд оролцож санал бодлоо илэрхийлсэн болно. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Үндэсний хороо | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Төрийн бүтээмжийн хэлэлцүүлэгт оролцсон байх | 1-р сарын 21-ний өдөр Төрийн ордонд зохин байгуулсан “Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд процессын дахин инженерчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон. | 01.01-06.10 | 100 |
| 18 | Зөвлөлдөх уулзалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2025 | Монгол Улсын Ерөнхийлөгийн санаачилсан “Цагаан алт” зөвлөлдөх уулзалт оролцсон байх. | 02-р сарын 20-ний өдөр зохион байгуулагдсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн-төр” хувийн хэвшлийн анхдугаар зөвлөлдөх уулзалтад оролцсон болно. | 01.01-06.10 | 100 |
| 19 | Үндэсний хороо | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | үндэсний хорооны хуралд оролцсон байх. | 5-р сарын 16-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны хуралд оролцсон болно. | 01.01-06.10 | 100 |
| ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ | | | | | | | |
| 1 | Ажлын хэсгийн даргаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.02.27-ны өдрийн А/124-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хурлыг 3-р сарын 10-ны өдөр ЭУХ-ийн дарга Цэндсүрэнтэй хамт зохион байгуулсан болно. | 01.01-06.10 | 100 |
| 2 | Ажлын хэсгийн ахлагчаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2025.04.16-ны өдрийн А/152-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | Төсвийн орлогыг биелүүлэхтэй холбоотой гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн хүрээнд татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөөг 04-р асрын 07-ны өдөр батлаж, хуралдааныг 3 удаа зохион байгуулан ажилласан. | 01.01-06.10 | 100 |
| 3 | Ажлын хэсгийн ахлагчаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2025.06.16-ны өдрийн А/250-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | ISO 9001:2015 “Чанарын удирдлагын тогтолцоо” стандарт болон ISO 27001:2022 “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо стандартуудыг үе шаттайгаар нэвтрүүлж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 6-р сарын 18-нд хуралдуулж ажлын чиглэлээр хանган ажиллав. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Ажлын хэсгийн ахлагчаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2023.11.22-ны өдрийн А/537-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 06-р сарын 10-ны өдөр шинэчилэн батлан ажиллаж байна. | 01.01-06.10 | 100 |
| 5 | Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн хэрэгжилтийг сайжруулж, улсын орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээний удирдамж баталж, ажлын хэсгийн гишүүдэд хяналт тавьж ажилласан байна. | ГЕГ-ын даргын 2025.02.03-ны өдрийн А/30 дугаар тушаалаар батлагдсан Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Тухайлбал, Хүнсний баталгаат байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хорио цээрийн хяналтын талаарх мэдээллийг холбогдох газарт хүргүүлсэн. | 01.01-06.10 | 100 |
| 6 | Үнэлгээний багийн ахлагчаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.12.05-ны өдрийн А/628-р тушаалаар байгуулагдсан үнэлгээний багийн ахлагчаар ажилласан байна. | Албан хаагчдийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах мэдээлэх үүрэг бүхий үнэлгээний багийн гишүүдийг 1 удаа хуралдуулж, хүн нэг бүрээр хэлэлцэн үнэлгээг нэгтгэж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн болно. | 01.01-06.10 | 100 |
| 7 | Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны дарга | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын ...-ны өдрийн А/...-р тушаалаар байгуулагдсан Мэргэжлийн зөвлөлийг хуралдуулсан байх. | Мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг 7 удаа зохион байгуулан хуралдуулж, хэлэлцсэн асуудлаар тушаал шийдвэрийг тухай бүр гаргуулан ажилласан. | 01.01-06.10 | 100 |
| 8 | Сахилгын хорооны дарга | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2025.06.02-ны өдрийн А/241-р тушаалаар байгуулагдсан Сахилгын хороог хуралдуулсан байх. | Сахилгын хороог 5 удаа зохион байгуулан хуралдуулж, хэлэлцсэн асуудлаар тушаал шийдвэрийг тухай бүр гаргуулан ажилласан. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Батлагдсан удирдамжийн дагуу газар хороодод ажиллах. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу харъяа гаалийн газар хороодод ажилласан байна. | ГЕГ-ын даргын 2025.05.28-ны өдрийн А/228-р тушаалаар “Ази Номхон далайн цаасгүй худалдааны долоо хоног” арга хэмжээнд оролцсон. Батлагдсан удирдамжийн дагуу 03-р сарын 20-23-ны өдрүүдэд Ханги хилийн боомт, 03-р сарын 29-30-ны өдрүүдэд Шивээхүрэн хилийн боомт, 05-р сарын 09-11-ний өдрүүдэд Замын-Үүд, Сайншанд дахь гаалийн газарт , Говийн бүсийн хуралдаанд тус тус оролцсон. | 01.01-06.10 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Монгол бичгийн зөв бичих чадварыг сайжруулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Дүрмээ сайжруулж алдаагүй бичдэг болох | Монгол бичгийг бие даан судлаж, зөв бичих дүрэм сайжирсан. | 01.01-06.10 | 100 |
| 2 | Ажлын хэсэг, уулзалтад оролцож санал бодлоо илэрхийлэх, гадаад болон дотоод үйл ажиллагаанд оролцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Үр дүнг тооцож сайн туршлагыг хэрэгжүүлэх | УИХ, ЗГХЭГ, ЯАМ болон бусад ажлын хэсгийн хурал хэлэлцүүлэгт 29 удаа оролцож гаалийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгт хамаарах асуудлаар саналаа илэрхийлж оролцсон. Мэргэжлийн зөвлөл, Захиргааны зөвлөл, Сахилгын хороо зэрэг 16 хурал, хяналт шалгалттай холбоотой семинар, уулзалтад 13, гадаад хамтын ажиллагааны чиглэлээр 10 уулзалтад оролцсон байна. Түүнчлэн гадаад болон дотоод томилолтоор 4 удаа, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 1 удаа ярилцлага өгөх, хяналт шалгалтын чиглэлээр 13 удаагийн хурал уулзалтад оролцсон болно. | 01.01-06.10 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГЫН

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: ........................ /Г.ЭНХТАЙВАН/

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХТАЙВАНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 61,3 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Монгол бичгийн зөв бичих чадварыг сайжруулах | | 15 |
| 2. | Ажлын хэсэг, уулзалтад оролцож санал бодлоо илэрхийлэх, гадаад болон дотоод үйл ажиллагаанд оролцох | | 15 |
| **Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 13 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 12 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 12 |
| 4. | Манлайлах | 12 |
| 5. | Багаар ажиллах | 12 |
| 6. | Харилцаа | 13 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 13 |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 61,3 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 13 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 89,3 |

**Үнэлгээ өгсөн:**

Гаалийн ерөнхий газрын дарга

**Төсвийн шууд захирагч:**

................ (Р.Отгонжаргал)

.............................. (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

**Нэгжийн дарга:**

........................ (Г.Энхтайван)

2025.06.10.......... (огноо)